



WWF

BOOK


MNG



The Project is funded  
by the European Union



УУЛ УУРХАЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАД  
ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ МЭДЛЭГ,  
ХАНДЛАГА, ДАДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН





# УУЛ УУРХАЙН ШИЙДВЭР ГАРГАЛТАД ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

“УУЛ УУРХАЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТӨНД ТАЛУУДЫН ОРОЛЦООГ  
НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР МОНГОЛ ОРНЫ АРД ИРГЭД, МАЛ СҮРГИЙН ЭРҮҮЛ АМЬДРАХ  
ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ БА БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ НЬ” ТӨСӨЛ

## ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА:

Дэлхийн байгаль хамгаалах сангийн  
Монгол дахь хөтөлбөрийн газар

## ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА:

“Ногоон Хөгжлийн Хөтөч” ТББ

# АГУУЛГА

<b>НЭГ. УДИРТГАЛ</b>	<b>6</b>
1.1 Үндэслэл	6
1.2 Зорилго	6
1.3 Арга зүй	7
<b>ХОЁР. ОРОН НУТГИЙН ИРГЭД БОЛОН ЗАСАГ ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛИЙН ТҮВШИН, ХАНДЛАГА</b>	<b>9</b>
2.1 Орон нутгийн иргэдийн уул уурхайн талаарх мэдээлэлтэй байдал	9
2.2 Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн талаарх орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудын мэдээлэлтэй байдал	13
2.3 Орон нутгийн иргэдийн мэдээлэл авч буй давтамж	16
<b>ГУРАВ. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b>	<b>18</b>
3.1 Орон нутгийн иргэдийн ОНБ-ын гишүүнчлэл, оролцоо	18
3.2 Орон нутгийн иргэдийн оролцооны туршлага, санаачлага	20
3.3 Уул уурхайн төлөвлөлт, шийдвэр гаргалтад иргэдийн оролцооны талаарх ойлголт хандлага	21
3.4 Уул уурхайн төлөвлөлт, шийдвэр гаргалтад иргэдийн оролцооны төлөв байдал	23
<b>ДӨРӨВ. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАЛУУДЫН ОРОЛЦООГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ</b>	<b>26</b>
4.1 Орон нутгийн иргэдийн хүсч буй мэдээлэл	26
4.2 Орон нутгийн иргэд, малчдад мэдээлэл хүргэх, оролцоог хангах нь	27
4.3 Уул уурхайн компанийн байр суурь	31
<b>ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ</b>	<b>34</b>
<b>ХАВСРАЛТ</b>	<b>38</b>
1. Асуулгын хуудас (иргэд, малчид)	38
2. Асуулгын хуудас (Орон нутгийн мэргэжилтэн)	39
3. Асуулгын хуудас (Уул уурхайн ААН)	47

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОУХБ	Байгаль орчны улсын хяналтын байцаагч
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНБ	Олон нийтийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТВ	Телевиз
УИХ	Улсын Их Хурал

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1.1** Иргэдийн мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх судалгааны түүврийн хэмжээ болон байршил
- Хүснэгт 1.2** Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн мэдээлэл, хувиар болон сумдаар (N=454)
- Хүснэгт 2.1** Уул уурхайн мэдээлэл авч буй эх үүсвэр
- Хүснэгт 2.2** Уул уурхайн үйл ажиллагааны талаарх иргэдийн мэдээлэл авах, мэдээллээр хангагдсан байдалд иргэдийн өгсөн үнэлгээ
- Хүснэгт 2.3** Иргэдийн зүгээс уурхайн нөлөөллийн асуудлаар ханддаг эсэх (Удирдлага, мэргэжилтэн, N=71)
- Хүснэгт 2.4** Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин, байгалийн нөөцүүдэд үзүүлж буй нөлөөлөл (Иргэд, N=454)
- Хүснэгт 2.5** Уул уурхайн асуудлаар оролцогч талууд хэр зэрэг итгэл үнэмшилтэй зүйл ярьж, мэдээлдэг вэ? асуултад орон нутгийн удирдлага, мэргэжилтний өгсөн хариулт (N=71)
- Хүснэгт 2.6** Орон нутгийн иргэдийн уул уурхайн талаарх мэдээлэл авах боломжийг үнэлсэн үнэлгээ, сумдаар (Орон нутгийн удирдлага, мэргэжилтэн N=454)
- Хүснэгт 3.1** Үнэлгээнд хамрагдсан иргэдийн ОНБ-ын гишүүнчлэлийн байдал, сумдаар (Иргэдийн асуулга, N=454)
- Хүснэгт 3.2** Орон нутгийн байгаль хамгаалах үйл ажиллагааны туршлага
- Хүснэгт 3.3** Нутгийн иргэдийн байгаль хамгаалах санаачлага, оролцоог хамгийн их дэмждэг институци байгууллага, хүмүүс (N=454)
- Хүснэгт 3.4** Уул уурхайн төлөвлөлт, үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах талаарх орон нутгийн удирдлага, албан хаагчдын ойлголт хандлага (N=71)
- Хүснэгт 3.5** Уул уурхайтай холбоотой асуудлаарх сургалт, хурал уулзалтад иргэдийн оролцсон байдал (n=454)
- Хүснэгт 3.6** Уул уурхайтай холбоотой асуудлаар иргэдтэй зөвлөлдсөн байдал(n=454)
- Хүснэгт 3.7** Уул уурхайн дараах үйл ажиллагаанд иргэдийн оролцсон хувь (N=454)
- Хүснэгт 4.1** Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах сургалтын хэрэгцээ
- Хүснэгт 4.2** Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах хүрээнд иргэдэд хэрэгцээтэй байгаа мэдээлэл, сумдаар
- Хүснэгт 4.3** Иргэдэд уул уурхайн мэдээллийг хүргэх арга замууд, сумдаар (Иргэдийн асуулга, N=454)
- Хүснэгт 4.4** Орон нутагт уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААН дараах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулж хамтран ажилласан туршлага, хувиар

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 2.1** Орон нутгийн иргэдийн уул уурхайн үйл ажиллаганы мэдээлэлтэй байдал (N=454)
- График 2.2** Орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийн уул уурхайн үйл ажиллагааны мэдээлэлтэй байдал (N=71)
- График 2.3** Нутгийн иргэдийг оролцуулсан хурал уулзалтын давтамж
- График 2.4** Уул уурхайн компаниас иргэдийг мэдээлэлжүүлж буй хэлбэр
- График 3.1** Иргэдийн идэвх оролцоот үйл ажиллагаа (удирдлага, мэргэжилтний асуулга N=71)
- График 3.2** Уул уурхайн үйл ажиллагаанд хэний оролцоотой хяналт тавих вэ (удирдлага, мэргэжилтний асуулга N=71)
- График 3.3** Уул уурхайтай холбоотой асуудлаар иргэдтэй зөвлөлддөг байгууллага (N=454)
- График 3.4** Уул уурхайн төлөвлөлт, үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах талаарх иргэдийн ойлголт хандлага (N=454)
- График 4.1** Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах уулзалт сургалт, хэлэлцүүлэгт оролцох сонирхол (N=454)
- График 4.2** Уул уурхайн үйл ажиллагаанд талуудын тэнцвэртэй оролцоог хангах хууль тогтоомж, тушаал шийдвэрийн талаарх мэдээллэтэй байдал

# НЭГ. УДИРТГАЛ

## 1.1 ҮНДЭСЛЭЛ

“Уул уурхайн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар Монгол орны ард иргэдийн болон мал сүргийн эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх ба байгаль орчныг хамгаалах нь” төсөл хоёр жилийн хугацаатай хэрэгжих ба “Ногоон Хөгжлийн Хөтөч” ТББ-ын үндэсний болон олон улсын 6 зөвлөх сонгогдон төслийн багт ажиллаж байна.

Уул уурхайн үйл ажиллагаанд хамтын ажиллагааны үр өгөөжтэй бүтэц, тогтолцоог нэвтрүүлэх боломжийг бий болгоход төслийн зорилго чиглэх бөгөөд Увс аймгийн Бөхмөрөн сумын Хотгор, Хэнтий аймгийн Батширээт сумын Гутайн даваа орчмын бүс нутгийг хамран хэрэгжиж байна.

Төслийн зорилгын хүрээнд дараахь зорилтууд хангагдана. Үүнд:

- 1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон уул уурхайтай холбогдох хууль тогтоомжийг зохистой хэрэгжүүлэх, олон нийтийн чадварлаг оролцоог бэхжүүлэх замаар эрүүл байгаль орчныг цогцлоон хамгаалах эрхийг бүрдүүлэх,
- 2 Байгаль орчны ОНБ-ын чадавхийг бэхжүүлж хамтын ажиллагааг хөгжүүлсний үр дүнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд иргэдийн оролцох эрхийг ханган бэхжүүлэх мөн уул уурхайн шийдвэр гаргах үйл явцад бодитой нөлөөтэй оролцоог хөгжүүлэх,
- 3 Олон нийтийн сурталчилгааг хэрэгжүүлэх замаар уул уурхайн нөлөөлөлд өртөж буй малчдын оролцоог хөгжүүлэхэд онцгой анхаарал тавьж, оролцох эрхээр ханган бэхжүүлэхэд оршино.

Малчид, нутгийн иргэд, ОНБ, орон нутгийн удирдлага, албан хаагчид, уул уурхайн ААН нь төслийн үйл ажиллагаанд хамрагдана. “Мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх” судалгаанд төслийн зорилтот бүлгүүдийг хамруулж, судалгааны үр дүнд тулгуурлан сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулах юм.

## 1.2 ЗОРИЛГО

Дэлхийн байгаль хамгаалах сан, Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ-ийн Зөвлөх баг хамтран “Уул уурхайн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар Монгол орны ард иргэдийн болон мал сүргийн эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх ба байгаль орчныг хамгаалах нь” төслийн хүрээнд сонгогдсон аймаг, сум, багын зорилтот бүлгийн оролцогч талуудын уул уурхайн шийдвэр гаргалтад оролцох оролцоог тодорхойлоход судалгааны зорилго оршино.

### 1.3 АРГА ЗҮЙ Судалгааг тоон болон чанарын арга зүйд үндэслэн суурь мэдээллийг цуглуулсан.

**Иргэдийн асуулгын хуудсаар** нийгэм, хүн ам зүйн мэдээлэл, иргэдийн идэвхи оролцоо, мэдлэг, хандлага, уул уурхайн мэдээллийн эх сурвалж, төсөл хэрэгжих хугацаанд иргэдийг мэдээлэлжүүлэх, оролцоог бий болгох, чадавхижуулах хэрэгцээг үнэлсэн.

**Орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийн асуулгын хуудсаар** уул уурхайн мэдээллийн эх үүсвэр, мэдээллийн ил тод нээлттэй байдал, уул уурхайн шийдвэр гаргалтад талуудын оролцооны өнөөгийн байдал, төсөл хэрэгжих хугацаанд оролцоог сайжруулах арга замыг тодорхойлсон.

**Ярилцлага, бүлгийн хэлэлцүүлгээр** төсөл хэрэгжих бүс нутаг дахь уул уурхайн шийдвэр гаргалтад оролцогч талуудыг хамруулан төслийн хүрээнд иргэд, захиргаа, ААН-д чиглэсэн талуудын тэнцвэртэй оролцоог хангах хүрээнд хэрэгжүүлэх сургалт, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа, талуудын тэнцвэртэй оролцоог бий болгоход чиглэсэн арга хэмжээний саналыг боловсруулах зорилготой чанарын мэдээлэл цуглуулсан.

**Түүврийн хэмжээ.** “Мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх” судалгааны түүврийн хэмжээг тогтоохдоо сумдын хүн амын тоо болон төслийн үнэлгээ мониторингийн судалгаанд тавигддаг түүврийн техникийг баримтлан 525 хүн амыг хамруулах нь зохистой гэж үзсэн ба түүврийн бус алдаа, хариултын хүчинтэй байдлыг (response rate) тооцож тогтоосон. Судалгаанд хамрагдсан хүн амын хувьд нийт эх олонлогийн 5-10 хувийг төлөөлөх нөхцлийг хангаж байгаа болно.

Түүврийн анхдагч нэгжийг сонгохдоо санамсаргүй сонголттой түүвэрлэлтийн техникийг хэрэглэв.

**Хүснэгт 1.1**  
Иргэдийн “Мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх” судалгааны түүврийн хэмжээ болон байршил

Үзүүлэлт	Орон нутгийн иргэний тоо	Дүнд эзлэх хувь	Орон нутгийн удирдлага, албан хаагчийн тоо	Дүнд эзлэх хувь
Аймаг				
Хэнтий	236	52.0	30	42.3
Увс	218	48.0	41	57.7
Сум				
Батширээт	188	41.4	14	36.6
Биндэр	48	10.6	16	21.1
Бөхмөрөн	218	48.0	41	42.3
Нийт	454	100.0	71	100.0

Орон нутгийн иргэдийн “Мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх” судалгаанд Хэнтий аймгийн Батширээт, Биндэр болон Увс аймгийн Бөхмөрөн сумын нийт 454 иргэн, орон нутгийн 71 удирдах ажилтан, албан хаагчид хамрагдлаа.



**Хүснэгт 1.2**  
Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн мэдээлэл, хувиар болон сумдаар (N=454)

Үзүүлэлт	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
<b>Насны бүлэг</b>				
19-24	2.1	8.3	8.3	5.7
25-29	5.9	8.3	26.1	15.9
30-39	26.1	29.2	21.7	29.1
40-49	29.3	20.8	13.8	20.9
50-59	21.3	10.4	15.6	17.4
60-69	10.6	14.6	2.3	7.0
70+	4.8	8.3	2.3	4.0
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	59.6	64.6	47.2	54.2
Эмэгтэй	40.4	36.4	52.8	45.8
<b>Боловсрол</b>				
Дээд	23.4	25.0	30.3	26.9
Тусгай дунд	10.1	8.3	10.6	10.1
Бүрэн дунд	43.1	47.9	24.8	34.8
Бүрэн бус дунд	19.7	10.4	24.3	20.9
Бага, боловсролгүй	3.7	8.3	10.1	7.2
<b>Ажил эрхлэлт</b>				
Төрийн байгууллага	21.3	27.1	24.8	23.6
Хувийн хэвшил	5.3	0.0	5.5	4.8
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	13.3	10.4	7.3	10.1
Тэтгэвэр, тэтгэмж	12.8	20.8	9.2	11.9
Малчин	25.5	27.1	18.3	22.2
Тариаланч, ногоочин	1.1	2.1	0.0	0.7
Ажилгүй	19.7	2.1	34.4	24.9
Бусад	0.5	6.3	0.5	1.1
Хариулахаас татгалзсан	0.5	6.3	0.5	1.1
Өрхийн сарын орлогын дундаж орлого	255274	227407	247391	250486
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>N</b>	<b>188</b>	<b>48</b>	<b>219</b>	<b>454</b>

Судалгаанд оролцогчдын дундаж нас 42, эрэгтэйчүүд 54.2 хувь, эмэгтэйчүүд 45.8 хувийг эзэлж байна. Боловсролын түвшний хувьд 26.9 хувь нь дээд, 34.8 хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа нь бусад боловсролын түвшинтэй харьцуулахад өндөр хувьтай үзүүлэлт болж байна.

Иргэдийн 23.6 хувь нь төрийн байгууллагад, 14.9 хувь нь хувийн хэвшлийн болон хувиараа бизнес эрхэлдэг, 22.2 хувь нь малчин, 11.9 хувь нь тэтгэвэр тэтгэмжид, 24.9 хувь нь ажилгүй иргэд эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн өрхийн сарын дундаж орлого 250486 (хоёр зуун тавин мянга дөрвөн наян зургаа) төгрөг байгаа нь амьжиргааны баталгаажих доод түвшнөөс доогуур орлоготойг харуулах үзүүлэлт мөн боловч орлогоо бууруулж мэдээлдэг хандлага нөлөөлж байх талтай. Мөн судалгаанд орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй салбарт ажиллагсад тухайлбал малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид түлхүү хамрагдсан нь өрх бага орлоготой харагдахад нөлөөлж байна.

# ХОЁР. ОРОН НУТГИЙН ИРГЭД БОЛОН ЗАСАГ ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛИЙН ТҮВШИН, ХАНДЛАГА

## 2.1 ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН УУЛ УУРХАЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙДАЛ

Нутгийн иргэд, орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид уул уурхайн мэдээллийг олон эх үүсвэрээс авч байна. Иргэд телевиз, нутгийн иргэдийн ам дамжсан яриа, багийн хурал, найз нөхөд, сошиал сүлжээгээр мэдээлэл авдаг бол орон нутгийн албан хаагчдын хувьд сум орон нутгийн холбогдох асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон уул уурхайн ААН-ээс авдаг гэж мэдээлсэн хувь бусад мэдээллийн эх үүсвэртэй харьцуулахад өндөр байна.

**Хүснэгт 2.1**  
Уул уурхайн мэдээлэл  
авч буй эх үүсвэр

Эх үүсвэр	Иргэдийн асуулга	Удирдлага, албан хаагчдын асуулга
Телевиз	85.7	25.4
Орон нутгийн телевиз	6.8	-
Радио	2.4	-
Өдөр тутмын сонин	5.9	2.8
Шар сонин	0.7	-
Уул уурхайн ААН	4.6	39.4
Багийн хурал	30.4	-
Сум, ИТХ-ын хурал	12.8	-
Орон нутгийн удирдлага, мэргэжилтэн	4.4	78.9
ОНБ \ТББ, нөхөрлөл\	5.3	23.6
Тойргийн УИХ-ын гишүүн	3.7	-
ОУ-ын төсөл, хөтөлбөрийн хурал, уулзалт	4.4	-
Ам дамжсан яриа	45.6	-
Гэр бүлийн гишүүд	8.6	-
Найз нөхөд	17.8	-
Цахим хуудас, фейсбүүк	17.6	12.7
Гарын авлага, тараах материал	4.0	1.4
Малчдаас мэдээлэл авдаг	-	21.1
Иргэнээс ирсэн санал гомдол	-	42.3
Самбар	6.6	-
Бусад	0.7	-

*Тайлбар: Олон сонголттой хариултын хувилбараар хариулсан тул 100 хувьтай тэнцэхгүй*


Судалгааны дүнгээр, иргэдийн авч буй мэдээллийн эх үүсвэрт ам дамжсан яриа голлох мэдээллийн эх үүсвэр болж байхад нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын хувьд уул уурхайн ААН, орон нутгийн мэргэжилтнүүдээс мэдээлэл авч байх жишээтэй. Иргэд

ам дамжсан буюу баталгаа, нотолгоогүй, албан бус мэдээллээр хангагддаг нөхцөл байдал тоон судалгааны үр дүнгээр ажиглагдаж байна.


Орон нутгийн албан хаагчдад уул уурхайн нөлөөлөлтэй холбоотой асуудлаар иргэдээс ирүүлдэг санал гомдол нь (42.3%) тэдний хувьд уул уурхайн мэдээлэл авдаг гол эх үүсвэрүүдийн нэг болж байна.

Судалгаанд оролцсон иргэдийн 75.2 хувь, орон нутгийн захиргааны албан хаагчдын 15.5 хувь нь уул уурхайн үйл ажиллагааны талаар хангалтгүй мэдээлэлтэй байна. Нутгийн иргэдийн 2.6 хувь нь уул уурхайн үйл ажиллагааны тухай маш сайн мэдээлэлтэй, 22.2 хувь нь ерөнхий мэдээлэлтэй байна. Бүлгийн хэлэлцүүлгийн үр дүнгээр, иргэд уурхайн талаарх мэдээлэлтэй байдлаа хангалтгүй хэмээн үнэлэхэд уул уурхайн компанийн ажилтны тоо, ашиг орлого, ашигт малтмалын нөөцийг нууцалдаг байдал, орон нутагтай хамтарч ажиллах менежмент, орон нутгаас хичнээн тооны ажилчин авах гэх мэт иргэдийн анхаарч сонирхдог мэдээлэл ил тод, нээлттэй бус байгаа нь нөлөөлдөг аж.

**График 2.1**  
Орон нутгийн иргэдийн уул уурхайн үйл ажиллагааны мэдээлэлтэй байдал (N=454)



**График 2.2**  
Орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийн уул уурхайн үйл ажиллагааны мэдээлэлтэй байдал (N=71)



Хүснэгт 2.2-т үзүүлснээр, ТЭЗҮ, БОННУ, нөхөн сэргээлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын тухай мэдээлэлгүй болохоо нийт судалгаанд оролцсон иргэдийн 82.6-88.1 хувь нь илэрхийлжээ. Орон нутгийн захиргааны байгууллага, ААН хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд тухайн орон нутагт хэрэгжих төслийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй байлгах үүрэг хүлээдэг. Энэхүү үүргийн биелэлт хангалтгүй байгааг тоон болон чанарын судалгааны үр дүн харуулж байна.

Чанарын судалгаанд оролцсон иргэд орон нутгийн захиргааны байгууллага, ААН-ийн аль аль нь уул уурхайтай холбоотой мэдээллээ ил тод, нээлттэй тавьдаггүй, тогтмол мэдээллээр хангадаггүй хэмээн шүүмжилсэн юм.

**Хүснэгт 2.2**

Уул уурхайн үйл ажиллагааны талаарх иргэдийн мэдээлэл авах, мэдээллээр хангагдсан байдалд иргэдийн өгсөн үнэлгээ

Үзүүлэлтүүд	Сайн мэдээлтэй	Ерөнхий мэдээлэлтэй	Мэдээлэлгүй	Нийт
Тусгай зөвшөөрөл	7.0	36.8	56.2	100.0
Уул уурхайн ААН-ийн үйл ажиллагаа	12.8	37.7	49.6	100.0
ТЭЗҮ	2.2	12.1	85.7	100.0
БОННУ	3.1	14.3	82.6	100.0
Нөхөр сэргээлт	2.4	9.5	88.1	100.0
Уурхайгаас үүдэлтэй хүний эрхийн зөрчил	8.6	18.3	73.1	100.0
Уурхайн хууль зөрчсөн үйлдэл	10.4	17.2	72.5	100.0
Уурхай эхлүүлэхийн өмнө иргэдийн оролцоог хангадаг байдал	6.2	16.1	77.8	100.0
Тусгай зөвшөөрөл олгосны дараа иргэдийн оролцоо	5.1	14.3	80.6	100.0
Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор	2.2	11.7	86.1	100.0

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход Ашигт малтмалын тухай хуулиар нутгийн захиргааны байгууллагаас санал авсны үндсэн дээр шийдвэр гаргах зохицуулалттай ч, тухайн санал авах үйл явц хуулиар зохицуулагдаагүйгээс хэрэгжихгүй байна. Энэ нь иргэдийн мэдээлэл авах, оролцох эрхийг хязгаарласаар байна.

Увс, Хэнтий аймагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн ихэнх нь олон нийттэй харилцах бүтэц, мэргэжилтэн байхгүй байна. Мөн ганцаарчилсан ярилцлагын дүнгээр уул уурхайн төлөөлөл уурхайн үйл ажиллагаа эхлээгүй тул тухайн орон нутгийн хүн, малын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэл бага хэмээн уурхайн удирдлагын төлөөлөл тайлбарласан юм. Уул уурхайн ААН-үүдийн хувьд талуудын тэнцвэртэй оролцоог хангах, ялангуяа иргэдийн оролцоог хангах, хамтран ажиллах, хууль тогтоомж, журмын талаар ерөнхий мэдээлэлтэйг ганцаарчилсан ярилцлагын дүн харуулсан.


Чанарын мэдээллийн шинжилгээнд тулгуурлан дүгнэхэд уул уурхайн ААН-үүдийн олон нийттэй харилцах менежмент сул, иргэдийн оролцоог хангах компанийн бодлого, чадавхиас шалтгаалж иргэдэд мэдээлэл өгөх, иргэдийн үр дүнтэй оролцоог бий болгоход хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж оролцдоггүй нөхцөл байдалтай байна. Хариуцлагатай уул уурхай, сайн засаглалын зарчмууд болох ил тод байдал, оролцоог ханган ажиллах нь орон нутгийн удирдлага, иргэдийн хувьд уул уурхайн компаниудтай сайн харилцааг хөгжүүлэхэд уул уурхайн компаниудын идэвх санаачлага, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах нь чухал байна.



Бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон иргэдийн дүгнэснээр, орон нутгийн удирдлага иргэдийн эрх ашгаас илүү уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААН-тэй ашиг сонирхол нэгддэг, иргэд бодитой мэдээллээр хомс, албан тушаалтнууд уул уурхайн асуудлаар иргэддээ зөв мэдээлэл өгч шударга ажилладаггүйд шүүмжлэлттэй хандсан. Харин орон нутгийн албан хаагчдын 53.5 хувь нь иргэд уул уурхай, байгаль орчны талаар хүссэн мэдээллээ авах боломжтой, 46.5 хувь нь иргэд хүссэн мэдээллээ авах боломж тааруу гэж үнэлсэн билээ. Төсөл хэрэгжих сумдаар харьцуулан шинжилсэн дүнгээр, Батширээт 40 хувь, Биндэр 50 хувь, Бөхмөрөн 40 хувь нь иргэд уурхайтай холбоотой хүссэн мэдээллээ авах боломжгүй байгааг тодорхойлжээ.

Шигтгээ 2.1	
<p>Уурхайг хариуцлагатай болгоход иргэдийн оролцоо чухал. Иргэн бид нутаглаж байгаа нутаг усандаа ямар хайгуул хийж байгааг мэдэх ёстой. Мэдээлэл ил тод биш. Уул уурхайг эхлүүлэх асуудлаар дан ганц Онон багийн иргэд оролцож, шийдвэр гаргаж байгаа нь буруу. Батширээтийн бүх иргэд оролцох ёстой. ААН, орон нутгийн удирдлага иргэдийн мэдээлэлгүйг их далимдуулдаг.</p> <p><i>(Уулзалт хэлэлцүүлэг, Хэнтий аймаг, Батширээт сум, ойн нөхөрлөлийн гишүүн)</i></p>	<p>Уул уурхай хөгжил муу түүхээр арвин, муу жишээ зөндөө. Жижиг болон дунд зэргийн уурхай нь нийгэм, байгаль орчны нөлөөлөлд анхаардаггүй. Уул уурхайг эхлүүлэхээс өмнө иргэд, сум орон нутгийнхныг оролцуулж хэлэлцүүлдэггүй. Байгаль орчны нөлөөллийг зөв тогтоож чадахгүй байна. Ард иргэдийг үйл ажиллагаандаа хамгийн сүүлд оролцуулдгаас олон нийтийн оролцоо үр дүнгүй байна.</p> <p><i>(Уулзалт хэлэлцүүлэг, Хэнтий аймаг, Биндэр сумын ЗДТГ-ын удирдах ажилтан)</i></p>

**График 2.2**  
Орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийн уул уурхайн үйл ажиллагааны талаарх үнэлэмж (N=71)



Орон нутгийн удирдлагуудын уул уурхайд хандах хандлагыг шинжлэхэд ялгаатай үр дүн ажиглагдлаа. Тодруулбал Хэнтий аймгийн Биндэр сумын удирдлага, мэргэжилтнүүдийн 60 хувь нь уул уурхайг дэмжихгүй байр суурьтай байгааг Биндэр, Бөхмөрөн сумтай харьцуулахад хамгийн өндөр хувьтай үзүүлэлт болж байна. Тоон судалгааны үр дүнг чанарын мэдээлэл давхар баталгаажуулсан үр дүнг үзүүлсэн юм.

**Шигтгээ 2.2**

Газрын баялаг нь УИХ, Засгийн газар, АМГ-ын өмч биш, ард түмний өмч, Гутайн давааны лицензийг цуцлах хүрээнд Онон голын сав дагуух газар алтны үндсэн орд ашиглуулбал хүн, мал, байгалийн нөөцүүдэд сэргэшгүйгээр аюул нүүрлэнэ, уул уурхайн урт хугацааны нөлөөллийг тооцоогүй, урт нэртэй хуулиас өмнө хариуцлагагүй уурхайг явуулж ирсэн ААН нөхөн сэргээлт хийгээгүй асуудлыг шийдээгүй нөхцөлд нэг ч уул уурхайг иргэд, удирдлагууд дэмжихгүй хатуу байр суурьтай байна.

*(Бүлгийн ярилцлага, Хэнтий аймгийн Биндэр сумын албан хаагчдын төлөөлөл)*

Сумын удирдлагын хувьд уул уурхайн төсөлд хамгийн ойр байж, нөлөөлөлд өртөж буй оролцогч талуудын эрх ашгийг хангаж хамгаалахад чухал үүрэгтэй субъект, газар ашиглах, ус ашиглах гэрээ байгуулах, уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих эрх үүрэг хуулиар олгогдсон байдаг. Иймд орон нутгийн удирдлага хуулиар олгогдсон эрх үүргээ биелүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж ажиллах шаардлагатай байгааг судалгааны дүн харуулж байна.

Нутгийн захиргааны байгууллага нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй компаниудын байгаль орчин, нийгмийн хариуцлагын тайланг хэлэлцэж, хамтын ажиллагааны гэрээ байгуулах зэргээр уул уурхайн компаниудтай сайн харилцааг хөгжүүлж хамтран ажилласан сайн туршлага манай улсад цөөнгүй байна.

Батширээт, Бөхмөрөн сумын удирдлага, мэргэжилтнүүд орон нутагт үр өгөөжөө өгөх хариуцлагатай уул уурхайг дэмжих чиглэлд санал нэгдсэн. (График 2.2)

**2.2**  
**УУЛ УУРХАЙН ҮЙЛ**  
**АЖИЛЛАГААНЫ**  
**НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ**  
**ОРОН НУТГИЙН**  
**ИРГЭД БОЛОН БУСАД**  
**ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН**  
**МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙДАЛ**

Уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг сөрөг гэж үнэлсэн хувь өндөр байгааг хүснэгт 2.3-т харуулсан үр дүнгээс харж болно. Жишээ нь 71.6 хувь бэлчээр, 71.3 хувь хөрс, 68.5 хувь усны нөөц, 61.2 хувь ургамлын төрөл зүйл, 61.8 хувь ан амьтанд сөрөг нөлөөтэй гэсэн хариулт өгчээ. Эндээс дүгнэхэд судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь уул уурхайн үйл ажиллагаа байгаль орчин, байгалийн нөөцүүдэд сөрөг нөлөөтэй хэмээн үзэж байна.

Чанарын дүн шинжилгээгээр иргэд уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр бэлчээр талхлагддаг, хөрсний эвдрэл, ус бохирдуулдаг, ан амьтан үргэж дайждаг, шороо тоос босдог, уул ухаж сэндийлэх зэргээр экосистемд учруулж буй хор хохирол ихтэй атлаа нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг орхигдуулдаг, нутгийн иргэд, малчид хохироод үлддэг муу жишигтэй тул уурхайг зогсоох саналтайгаа илэрхийлсэн. Уурхайн төлөвлөлт, үйл ажиллагааны явцад байгаль орчны нөлөөлөл, түүнийг бууруулах арга замуудыг сайтар судлан, байгаль орчны мэргэжилтнүүд, орон нутгийн засаг захиргаа болон нутгийн иргэдтэй хэлэлцэх шаардлага тулгамдсаар хэвээр байна.

**Хүснэгт 2.3**

Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин, байгалийн нөөцөд үзүүлж буй нөлөөлөл (Иргэд N=454)

Үзүүлэлт	Их сөрөг	Ер нь сөрөг	Нөлөөгүй	Мэдэхгүй	Нийт
Бэлчээр	50.0	21.6	4.6	23.8	100.0
Газрын хөрс	54.0	17.4	3.7	24.9	100.0
Ус, усны нөөц	50.2	18.3	4.6	26.9	100.0
Ургамал, түүний төрөл зүйл	42.7	18.5	5.7	33.0	100.0
Ан амьтан	40.7	21.1	6.6	31.5	100.0
Агаар	35.7	21.8	8.1	34.4	100.0
Ой	35.5	20.7	7.7	36.1	100.0
Газрын дээр, доорх баялаг	36.1	19.6	5.5	38.8	100.0
Нөлөөллийн бүс	27.8	20.9	3.7	47.6	100.0

Хуулийн хүрээнд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийг дэмжсэн байр суурьтай иргэд болон нутгийн удирдлага байгаль орчны менежментийн стандарт, журмуудыг талуудын оролцоотой тодорхойлж, тэдгээрийг бүх түвшинд мөрдүүлдэг тогтолцоотой болох, үүнд иргэд, малчдын хяналт чухал байгааг тэмдэглэсэн.

Орон нутгийн захиргааны албан хаагчдын хариулснаар, иргэд уул уурхайг ажиллуулахгүй байх асуудлаар орон нутгийн захиргаа, албан хаагчдад хандсан нь хамгийн өндөр хувьтай үзүүлэлт болж байна.

**Хүснэгт 2.4**

Иргэдийн зүгээс уурхайн нөлөөллийн асуудлаар ханддаг эсэх эсэх (Удирдлага, мэргэжилтэн, N=71)

Үзүүлэлт	Хандсан хувь
Уурхайн хууль бус үйл ажиллагаа	35.2
Уул уурхайн байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл	39.4
Уурхайг ажиллуулахгүй	46.5
Нөхөн олговор, газар чөлөөлөлт	5.6
Өмчлөх эрхэд халдсан асуудал	-
Уул уурхайн талаар мэдээлэл хүссэн асуудал	18.3
Уул уурхайтай холбоотой хууль, дүрэм журмын мэдээлэл хүсдэг	12.7
ИНБ, ТББ, өмгөөлөгчид хандах асуудал	-

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй хохирол, эрсдлийг тооцох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд иргэд болон талуудын оролцоог хангах нь үр дүнтэйг орон нутгийн удирдлага, уул уурхайн компаниуд анхаарах явдал чухал.

Иргэдийн хувьд ААН-д итгэх итгэлийг сулруулахад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

- ААН болон орон нутгийн захиргаа нь уул уурхайн үйл ажиллагаанаас нутгийн иргэдийн амьжиргаа, зан заншил, соёл уламжлалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байлгахад анхаарал хандуулдаггүй байдал,

- Уурхайн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн тухай бодит мэдээллийг иргэдэд танилцуулдаггүй байдал,
- Уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд иргэдийг оролцуулдаггүй байдал,
- Уул уурхайн байгаль орчин, иргэдийн амьжиргаанд учруулж буй асуудлаарх санал гомдлыг шийдэхгүй орхигдуулдаг байдал

Уул уурхайн салбарт байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой асуудлаар олон нийтийн эсэргүүцэл, хөдөлгөөнд хүрч байсан муу туршлага олон бий. Увс аймгийн Бөхмөрөн сумын иргэд алтны олборлолтын ААН-ийн үйл ажиллагааг эсэргүүцэн тэмцсэн шалтгаанд нутгийн иргэдийн уламжлалт оршуулгын зан үйл, соёлтой холбоотой асуудал хөндөгдсөн байдаг. Мөн ААН нь иргэдийн үр дүнтэй оролцоог хангаж, зөвлөлддөггүйгээс маргаан, эсэргүүцэл дагуулж, уурхайн үйл ажиллагаа нь зогсоход хүрсэн тохиолдол гарчээ.

Иргэд уул уурхайн талаар итгэл үнэмшилтэй, найдвартай мэдээллийг орон нутгийн албан хаагчдаас авдаг хэмээн албан хаагчид хариулжээ. Найдвартай мэдээлэл авдаг эх үүсвэрүүдийг өндөр давтамжаар эрэмбэлэхэд нэгдүгээрт асуудал хариуцсан мэргэжилтэн хоёрдугаарт, багийн засаг дарга, гуравдугаарт ой, байгаль хамгаалах нөхөрлөл орж байна.

Үнэмшил муутай буюу найдваргүй мэдээллээр хангадаг эх сурвалжид Засгийн газар тэргүүлж, нутгийн иргэд удаалж, сум орон нутгийн захиргаа гуравдугаарт орж байна. Уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн, нөлөөллийн бүс дэх засаг захиргааны анхан шатны нэгж буюу багийн засаг дарга, байгаль хамгаалах нөхөрлөлүүд найдвартай, бодитой мэдээллээр хангаж ажилладгийг судалгаанд оролцсон албан хаагчид хүлээн зөвшөөрсөн хариулт өгсөн юм.

Орон нутгийн захиргаа ба ОНБ-ын хооронд уул уурхайн асуудлаарх мэдээлэл солилцох үйл ажиллагаа, хамтын ажиллагаа сул байгааг бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон иргэд тэмдэглэсэн. (Хүснэгт 2.5)

### Хүснэгт 2.5

Уул уурхайн асуудлаар оролцогч талууд хэр зэрэг итгэл үнэмшилтэй зүйл ярьж, мэдээлдэг вэ? асуултад орон нутгийн албан хаагчдын өгсөн хариулт (N=71)

Үзүүлэлт	Маш үнэмшилтэй	Ер нь үнэн	Ер нь үнэмшилгүй	Огт үнэмшилгүй	Мэдэхгүй	Бүгд
Засгийн газар	2.8	38.0	25.4	8.5	25.4	100.0
Сум, орон нутгийн захиргаа	1.4	46.5	15.5	7.0	29.6	100.0
Асуудал хариуцсан мэргэжилтэн	15.5	52.1	4.2	2.8	25.4	100.0
Багийн засаг дарга	16.9	50.7	9.9	0.0	22.5	100.0



Орон нутгийн Хэвлэл мэдээлэл	5.6	12.7	5.6	1.4	74.6	100.0
Нутгийн хүндтэй хүмүүс	5.6	32.4	22.5	1.4	38.0	100.0
Ой, байгаль хамгаалах нөхөрлөл	9.9	45.1	8.5	0.0	36.6	100.0
Үндэсний хэвлэл мэдээлэл	12.7	36.6	9.9	1.4	39.4	100.0
Малчдын бүлэг	11.3	32.4	14.1	1.4	40.8	100.0
Загасчдын клуб	5.6	21.1	7.0	1.4	64.8	100.0
Эко клуб	8.5	22.5	7.0	1.4	60.6	100.0
Нөлөөллийн бүсийн иргэд	11.3	29.6	15.5	4.2	39.4	100.0
Судалгааны байгууллага	4.2	33.8	11.3	5.6	45.1	100.0
ТББ	0.0	4.2	4.2	2.8	88.7	100.0

Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоо сул байгаад малчид орон зайн хувьд таруу, хол нутагладаг, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, хувь хүний идэвх болон мэдээллийн хүртээмж нөлөөлдгийг сум, багийн удирдах ажилтнууд онцлон тэмдэглэсэн юм. Ялангуяа хавар төл бойжуулах, намар хадлан тэжээл авах, зун сааль сүүний цагаар малчид завгүй ажилладгийг багийн засаг дарга хэлж байлаа. Иймд иргэдийн оролцоог хангах үйл ажиллагааг төлөвлөхдөө малчдын улирлын шинжтэй ажлын ачааллыг тооцох хэрэгтэй болж байна.

### Шигтгээ 2.2

Хурлын тухай мэдээлэл малчдад бүрэн тардаггүй. Би өөрөө утсаар дахин дахин ярина, мөн малчдын бүлгийн ахлагчаар дамжуулж хэлүүлдэг. Мэдээлэл олж авахад иргэдийн боловсролын түвшин нөлөөлдөг. Сард 1-2 удаа багийн иргэдээрээ явдаг. Хуралд эмэгтэйчүүд илүү ирж оролцдог. Иргэд уул уурхайн талаар сонссон зүйлээ биднээс үнэн зөвийг лавлаж асуудаг.

(Ганцаарчилсан ярилцлага, Хэнтий аймаг, Баянгол багийн Засаг дарга)

## 2.3 ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ АВЧ БУЙ ДАВТАМЖ


Уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангахад мэдээлэл авч буй хэлбэр, давтамж чухал нөлөөтэй хүчин зүйл юм.

Судалгаагаар иргэдийн 0.2 хувь нь долоо хоног бүр, 4.6 хувь нь сар бүр, 6.6 хувь нь улирал бүр, 4.2 хувь нь хагас жилд 1-2 удаа, 20 хувь нь жилд 1-2 удаа уул уурхайтай холбоотой хурал, уулзалт, хэлэлцүүлэгт оролцдог гэж хариулсан бол 59.9 хувь нь мэдэхгүй мэдээлэл байхгүй гэж хариулжээ.


Судалгаагаар уул уурхайн компаниас уул уурхайн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах, ойлгуулах хүрээнд ямар мэдээлэл өгч, хамтран ажилладаг туршлага байгааг олон сонголттой хариултын хувилбараар тодруулахад:

- ААН олон нийтэд үйл ажиллагаагаа танилцуулах, мэдээлэх, тэднийг оролцуулах, зөвлөлдөх зорилгоор хуралд урьж оролцуулдаг 16.5 хувь, өрхөөр мэдээлэл хүргэдэг 4.6 хувь, бичгээр санал хүсэлт авдаг 3.7 хувь, БОННУ-г танилцуулдаг 1.1 хувьтай дүгнэгджээ. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх эхний алхам бол ААН тухайн орон нутагт хэрэгжүүлэх уул уурхайн төслөө иргэд, орон нутгийн захиргаанд танилцуулахаас эхлэдэг. Гэвч төсөл хэрэгжих бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй судлагдсан ААН-ийн олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулсан үр дүн гарч байна.

**График 2.3**  
Нутгийн иргэдийг оролцуулсан хурал уулзалтын давтамж



**График 2.4**  
Уул уурхайн компаниас иргэдийг мэдээлэлжүүлж буй хэлбэр



Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл олж авах эрх, эрх чөлөөг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан байдаг. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын 22.5 хувь нь уул уурхайтай холбоотой мэдээллийг иргэд авах бүрэн боломжтой, 31 хувь нь ер нь боломжтой гэж хариулсан байхад үлдсэн хувь нь иргэдийн мэдэх, мэдээлэл авах боломж хангалтгүйг илтгэх үзүүлэлтээр үнэлсэн юм.

**Хүснэгт 2.6**  
Орон нутгийн иргэдийн уул уурхайн талаарх мэдээлэл авах боломжийг үнэлсэн үнэлгээ, сумдаар (Орон нутгийн удирдлага, мэргэжилтэн N=454)

Үзүүлэлт	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
Бүрэн боломжтой	30.8	13.3	26.7	<b>22.5</b>
Ерөнхийдөө боломжтой	30.8	33.3	26.7	<b>31.0</b>
Дунд зэрэг	11.5	26.7	13.3	<b>18.3</b>
Боломж муутай	23.1	23.3	33.3	<b>25.4</b>
Мэдэхгүй	3.8	3.3	0.0	<b>2.8</b>
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

# ГУРАВ. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## 3.1 ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ОНБ-ЫН ГИШҮҮНЧЛЭЛ, ОРОЛЦОО

Уул уурхайн хууль бус үйл ажиллагаа, хүний эрхийн зөрчлийг арилгах, зөрчигдсөн эрхийг хангаж хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Онон Улз голынхон хөдөлгөөн ТББ Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумын иргэд, малчдыг оролцуулсан уулзалт, сургалт, уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчны нөлөөллийг тогтоох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутгийн иргэд, малчид байгаль хамгаалах, аргаль хамгаалах, ой хамгаалах, бэлчээр зохистой ашиглах зорилгоор нөхөрлөл, бүлгийн гишүүний статустайгаар ОНБ-д харъяалагдан үйл ажиллагаа явуулж байна.

Судалгаанд хамрагдсан Батширээт сумын иргэдийн 60.6 хувь, Биндэр сумын иргэдийн 45.8 хувь, Бөхмөрөн сумын иргэдийн 18.8 хувь нь ой, бэлчээр, байгаль хамгаалах нөхөрлөл, ТББ, клубийн гишүүний статустай байна. Энэхүү үзүүлэлт нь орон нутаг дахь ОНБ нь талуудын эрх тэгш оролцоот хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд ААН болон орон нутгийн удирдлагад шаардлага тавих, хамтран ажиллах боломж нөхцөл байгааг харуулж байна.

**Хүснэгт 3.1**  
Судалгаанд хамрагдсан иргэдийн ОНБ-ын гишүүнчлэлийн байдал, сумдаар (Иргэдийн асуулга, N=454)

Үзүүлэлт	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
Эмэгтэйчүүдийн ТББ	3.7	0.0	4.1	<b>3.5</b>
Ой, байгаль хамгаалах нөхөрлөл	49.5	37.5	8.7	<b>28.6</b>
Загасчдын клуб	1.6	0.0	0.0	<b>0.9</b>
ТББ	2.1	2.1	3.3	<b>2.4</b>
Малдчын бүлэг	3.2	6.3	2.3	<b>3.1</b>
Бусад	0.5	0.0	0.5	<b>0.4</b>
Гишүүнчлэлгүй	39.4	54.2	81.2	<b>61.0</b>
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид хамтын менежментийн зарчимд тулгуурласан ой, байгаль, бэлчээр хамгаалдаг бүлэг, нөхөрлөлийн гишүүдийн үйл ажиллагааг нэрлэсэн нь 80 шахам хувьтай байна. Уул уурхайн үйл ажиллагааны мөчлөгт орон нутгийн захиргааны байгууллага, нутгийн иргэдийн хяналт оролцоог чухалчилан үзэх хандлага нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийн дунд нийтлэг ажиглагдсан юм. (График 3.1, 3.2)

Олон нийтийн оролцоонд тулгуурласан байгаль хамгаалах уламжлалт үйл ажиллагаануудыг судалгаанд хамрагдсан иргэдийн нэрлэснээр дараах хүснэгтэд харуулав. Төсөл хэрэгжих Хэнтий, Увс аймгийн иргэд ой, байгаль хамгаалах, аргаль хамгаалах нөхөрлөл, бэлчээр хамгаалах

бүлгийн гишүүнээр ажиллаж, байгаль хамгаалалтын харилцаанд оролцож байгаа хувь 38.3 хувь буюу хамгийн өндөр давтамжтай илэрсэн бол хоёрдугаар эрэмбийн үзүүлэлтээр идэвхтэн байгаль хамгаалагчаар хамгаалагчаар ажилладаг гэж 31.5 хувь нь хариулжээ.

### Хүснэгт 3.2

Орон нутгийн байгаль хамгаалах үйл ажиллагааны туршлага


Үзүүлэлт	Хувь
Ой, байгаль хамгаалах нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын бүлгийн гишүүнээр ажилладаг	38.3
Идэвхтэн байгаль хамгаалагчаар ажилладаг	31.5
Булаг шандын эх хашдаг	28.6
Хулгайн анчид, самар жимсчдийг хөөдөг, орон нутгийн удирдлагад мэдээлдэг	7.9
Хууль бус мод бэлтгэгчидтэй тэмцдэг	18.1
Уул уурхайн хууль бус үйл ажиллагаатай газар дээр нь хэлж эсэргүүцдэг	13.2
Иргэдэд байгаль хамгаалах, экологийн боловсрол олгох чиглэлээр ТББ, ОНБ байгуулан ажилладаг	5.1
Ой, байгаль хамгаалах чиглэлээр нөхөрлөл, бүлэг байгуулан сум, багийн ЗД-тай гэрээтэй ажилладаг	18.5
Ой, байгалийн нөөцөд ямар нэгэн сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг ажиглаж байдаг, мэдээлдэг	11.9

Тайлбар: Давхардсан тоогоор хариулсан тул 100 хувьтай тэнцэхгүй

Нөхөрлөлийн гишүүд амьдарч буй газрын булаг шандыг хаших, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ой, байгаль хамгаалах үйл ажиллагаа явуулж, сумын Засаг даргатай гэрээ байгуулан ажилладаг туршлагатай байна. Зөвлөх баг одоо бий болсон энэхүү бүтцэд тулгуурлан уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог үр дүнтэй зохион байгуулахад чухал хөшүүрэг болно хэмээн таамаглаж байна.


### График 3.1

Иргэдийн идэвх оролцоот үйл ажиллагаа (удирдлага, мэргэжилтний асуулга N=71)



### График 3.2

Уул уурхайн үйл ажиллагаанд хэний оролцоотой хяналт тавих вэ (удирдлага, мэргэжилтний асуулга N=71)



### Шигтгээ 3.1

Уул уурхай орчны бүс, дархан цаазат газар үйл ажиллагаа явуулдаг. Үүний эсрэг иргэд нэгддэг. Манай нутаг дэвсгэрт ямар хайгуул байгааг иргэд мэдэх ёстой. ААН нь ашиглалтын зөвшөөрөл аваад ирдэг. Орон нутаг ААНийн хооронд зөрчил үүсдэг. Хариуцлагатай уул уурхай иргэдтэй тохиролцох ёстой, бүх талууд хамтарч ажиллах ёстой. Бөхмөрөнд байгаль хамгаалах, аргаль хамгаалах, бэлчээр хамгаалах олон нөхөрлөл байна. Загвар нөхөрлөл ч байна.

(Ганцаарчилсан ярилцлага. Увс аймаг, Бөхмөрөн сум, асуудал хариуцсан мэргэжилтэн)



### 3.2 ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ТУРШЛАГА, САНААЧЛАГА

Судалгаанд хамрагдсан иргэдийн хариулснаар, иргэдийн байгаль хамгаалах санаачлагыг нутгийн иргэд, малчид өөрсдөө дэмждэг гэж хариулсан нь хамгийн өндөр хувьтай дүгнэгджээ. Хоёрдугаарт ОНБ (нөхөрлөл), гуравдугаарт сум, багийн засаг даргыг нэрлэжээ. ААН-ийг нутгийн иргэдийн санаачлага, оролцоог дэмждэггүй байгууллагаар иргэд тодорхойлсныг тоон мэдээллийн дүн шинжилгээ харуулж байна.

**Хүснэгт 3.2**  
Нутгийн иргэдийн байгаль хамгаалах санаачлага, оролцоог хамгийн их дэмждэг институци байгууллага, хүмүүс (N=454)

Үзүүлэлт	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
Малчид, иргэд өөрсдөө	44.1	50.0	62.8	<b>53.7</b>
ОНБ	8.0	10.4	6.0	<b>7.3</b>
Нутгийн ой, байгаль хамгаалах нөхөрлөл	36.2	58.3	12.8	<b>27.3</b>
ОУБ-ын төсөл хөтөлбөр	2.1	20.8	5.5	<b>5.7</b>
Сум багийн ЗД, ИТХ	8.0	29.2	14.2	<b>13.2</b>
БОУБ	5.3	18.8	3.7	<b>5.9</b>
Уул уурхайн ААН	1.1	2.1	1.8	<b>1.5</b>

*Тайлбар: Олон сонголттой хариултын хувилбараар харуулсан тул 100 хувьтай тэнцэхгүй*

Судалгааны дүнгээр, уул уурхайн ААН, орон нутгийн иргэдийн хооронд эерэг харилцаа, хамтын ажиллагаа, тэгш оролцоог бий болгон, хөгжүүлэхэд орон нутгийн захиргаа хамгийн чухал үүрэгтэй институци болж байна. Төсөл хэрэгжих бүс нутгийн иргэдийн 13.2 хувь нь орон нутгийн захиргааг иргэдийн идэвх санаачлага, оролцоог дэмждэг гол байгууллагаар нэрлэжээ. Иймд уул уурхайн үйл ажиллагаанд талуудын идэвхтэй оролцоог бий болгох, дэмжих, хамтын ажиллагааны суурийг тавих, идэвхтэй түншлэлийг хөгжүүлэхэд орон нутгийн захиргааны байгууллага гол гүүр болох учиртай юм.

Дээрх санааг нотлох өөр баримт нь иргэд уул уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчин, байгалийн нөөц болон нутгийн иргэдийн амьжиргаа, аж ахуй, соёл уламжлалд нөлөөлсөн асуудлаар орон нутгийн удирдлага, албан хаагчдад хандсан тохиолдол хамгийн өндөр хувьтай илэрсэн байдаг. Төслийн зорьж буй уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн идэвхтэй оролцоог бий болгоход нутгийн удирдлага, албан хаагчид гол оролцогч тал болохыг судалгааны дүн харуулж байна.

Уул уурхайн шийдвэр гаргалтад талуудын тэнцвэртэй оролцоог хангахад, иргэд ба ААН хоорондын ойлголцол, хамтын ажиллагааг үр дүнд хүргэхэд орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүд голлох үүрэг хүлээж оролцох нь хамгийн оновчтой хувилбараар харж байна.

Орон нутгийн албан хаагчид иргэдийн хүсэлт, асуултад хариулт өгөх хэлбэрээр идэвхгүй мэдээлэл хүргэх биш, итгэлцлэлд суурилсан талуудын хамтын ажиллагааг бий болгох, уул уурхайтай холбоотой иргэдийн шаарддаг мэдээллийг ил тод, нээлттэй тавих, гурван талт хамтын ажиллагааны гэрээг байгуулах, гишүүдийг сонгон шалгаруулахаас эхлээд бүх харилцааг ил тод, нээлттэй байлгахыг талууд (иргэд, малчид) санал болгож байна.

Уул уурхайн ААН-ийн хувьд сум, багийн засаг дарга, БОУБ, нөлөөллийн бүсийн иргэд, малчидтай харилцахдаа хурал уулзалт хийх, малчин өрхөөр зочилж ААН-ийн үйл ажиллагааг танилцуулдаг байна.

**Матриц 3.1**

Иргэдийн зүгээс уул уурхайн компаниудаас авахыг хүсдэг мэдээлэл (Чанарын судалгааны дүн шинжилгээ)


Иргэдээс ААН-д хандаж авахыг хүсдэг мэдээлэл	Иргэдээс ААН-д гаргадаг санал, гомдол	Уул уурхайн ААН-ийн зүгээс өгч буй хариу
<ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн иргэдэд үзүүлэх эдийн засгийн үр ашиг</li> <li>- Ажлын байр</li> <li>- Уурхайн нөлөөлөл, баяжуулах үйл ажиллагаанаас үүдэх хор хөнөөл</li> <li>- Бэлчээр талхдалт</li> <li>- Иргэд мэдээлэл хүсч байгаагүй</li> <li>- Нөөцийн хэмжээ</li> <li>- Тусгай зөвшөөрлөө яаж авсан, ямар ААН эзэмшдэг, ямар үйл ажиллагаа явуулах талаар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль бус олборлолт хийдэг хүмүүсийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны эрсдэл</li> <li>- Орчин үеийн техник төхөөрөмж хэрэглэх</li> <li>- Тоосжилт их</li> <li>- Дуу чимээ их</li> <li>- Хөрс, бэлчээр бохирдуулдаг</li> <li>- Суваг шуудуу татуулахгүй байх асуудал</li> <li>- Иргэдэд ямар ашиг байна гэдэг асуудлаар</li> <li>- Нүүрс олгох хүсэлт ирдэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Нөхөрлөлтэй гэрээ байгуулан ажилладаг</li> <li>- Нутгийн иргэдийг боломжоороо ажилд авлаг</li> <li>- Тоосжилт, дуу чимээ бууруулах арга хэмжээ авдаг</li> <li>- Манай ААН ажиллах л болно гэдэг хариу өгдөг.</li> <li>- Нөлөөллийн бүсийн өрхөд нүүрс олгодог</li> <li>- Нэгдсэн замаар тээвэрлэлт, стандартын дагуу суваг шуудуу татсан тайлбар өгдөг</li> </ul>

**3.3 УУЛ УУРХАЙН ТӨЛӨВЛӨЛТ, ШИЙДВЭР ГАРГАЛТАД ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААРХ ОЙЛГОЛТ ХАНДЛАГА**

Судалгаагаар уурхайн шууд болон шууд бус нөлөөллийн бүсэд нутагладаг иргэдийн уул уурхайн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад иргэдийн оролцооны талаар ойлголтыг тодорхойлсныг хүснэгт 3.3-т үзүүлэв.

**График 3.3**

Уул уурхайн төлөвлөлт, үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах талаарх иргэдийн ойлголт хандлага (N=454)



Судалгаанд хамрагдсан 2 иргэн тутмын 1 нь уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах гэж чухам юуг ойлгож буйг

мэдэхгүй байна. Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн дуу хоолой, саналыг сонсох, уулзалт хэлэлцүүлэг өрнүүлж зөвлөлдөх, уул уурхайтай холбоотой хууль эрх зүйн мэдлэг, уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо сэдвээр сургалтанд хамрагдаж мэдлэг мэдээлэлтэй болсноор уул уурхайн шийдвэр гаргалтад иргэд хэрхэн оролцохоо мэдэж авна, мэдлэг мэдээлэлдээ тулгуурлан оролцоогоо хангаж ажиллана хэмээн иргэд хариуллаа.

Иргэдийн дунд ялангуяа Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумдын хувьд уул уурхайг эрс эсэргүүцсэн байр суурьтай байгааг чанарын судалгааны дүн харуулж байна.

### Матриц 3.2

Уул уурхайн төлөвлөлт, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах тухай иргэдийн дэвшүүлсэн санал (Чанарын судалгааны дүн шинжилгээ)

Батширээт	Биндэр	Бөхмөрөн
- Иргэд саналаа хэлж хэлэлцэж асуудлыг шийдэх - Иргэд, уурхайн удирдлага, захиргааны байгууллага хамтарсан холбоо - Иргэдээс зөвшөөрөл авсан тохиолдолд уурхайг эхлүүлэх - Уурхай эхлэхээс өмнө иргэдийн саналыг авдаг байх.	- Тухайн уул уурхайг эхлүүлэхийн өмнө иргэдэд мэдээлэл өгөх, хүргэх - Иргэдийг оролцуулж шийдвэр гаргах - Иргэдийн оролцоог хангах төлөвлөгөөтэй байх, үүний дагуу ажиллах - Уул уурхайн талын хуулийн мэдлэг оролцогч талуудад өгөх	- Иргэдийг байнга мэдээллээр хангах - Иргэдийн дуу хоолойг сонсох - Иргэдийн тавьсан санал гомдлыг хүлээн авч үйл ажиллагаандаа тусгах - Иргэд, малчидтай харилцан ярилцаж ойлголцох - Иргэдийн саналд үндэслэсэн шийдвэр гаргах

Судалгаанд хамрагдсан орон нутгийн захиргааны албан хаагчид уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийг оролцуулж, мэдээллээр хангаж, хамтарч ажилласнаар оролцоо бий болно гэж хариулснаас үзвэл иргэдтэй ижил байр суурьтай байгааг харуулж байна. Иргэд, албан тушаалтнууд уул уурхайн үйл ажиллагаанд саналаа илэрхийлэх, зөвлөлдөх, иргэдийн саналд тулгуурлан шийдвэр гаргах зэргээр иргэдийн бүтээлч, идэвхтэй оролцоог санал болгож, асуудалд хандаж байгаа нь сайшаалтай байна.

### Хүснэгт 3.3

Уул уурхайн төлөвлөлт, үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах талаарх орон нутгийн удирдах ажилтан, мэргэжилтнүүдийн ойлголт хандлага (N=71)

Үзүүлэлт	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
Иргэдийг ажлын байраар хангах	7.7	20.0	13.3	14.1
Үнэн зөв мэдээллээр тогтмол хангах	7.7	10.0	20.0	11.3
Иргэдийн оролцоот шийдвэр гаргах	15.4	16.7	6.7	14.1
Талууд хамтарч ажиллах	3.8	6.7	0.0	4.2
Сургалт, уулзалт тогтмол хийх	3.8	0.0	20.0	5.6
Талуудын эрх ашиг, сонирхол тэнцвэртэй байх	3.8	0.0	6.7	2.8
Мэдээлэл ил тод байх	15.4	13.3	6.7	12.7
Мэдэхгүй	7.7	10.0	0.0	7.0
Санал байхгүй	34.6	23.3	26.7	28.2

### 3.4 УУЛ УУРХАЙН ТӨЛӨВЛӨЛТ, ШИЙДВЭР ГАРГАЛТАД ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо ямар түвшинд байгааг судлахад хоёр иргэн тутмын нэг нь огт оролцож байгаагүй эсвэл мэдээлэл авч байгаагүй гэж хариулсан нь хамгийн өндөр хувийн жинтэй үзүүлэлт болж байна.

Увс аймгийн Бөхмөрөн сумын судалгаанд хамрагдсан иргэдийн тал хувь нь уурхайтай холбоотой асуудлаар зохион байгуулагдсан хурал уулзалт, хэлэлцүүлэгт оролцож байгаагүй гэж хариулсан нь Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумын иргэдтэй харьцуулахад мэдээлэлтэй байдал, оролцоотой байдлын үзүүлэлт доогуур түвшинд байна.

**Хүснэгт 3.5**  
Уул уурхайтай холбоотой асуудлаарх сургалт, хурал уулзалтад иргэдийн оролцсон байдал (n=454)

Үзүүлэлт	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
1 удаа	20.7	16.7	14.2	<b>17.2</b>
2 удаа	8.5	2.1	2.8	<b>5.1</b>
3 удаа	3.2	6.3	2.8	<b>3.3</b>
4 удаа	1.6	0.0	0.9	<b>1.1</b>
5 удаа	3.7	4.2	2.3	<b>3.1</b>
Огт оролцож байгаагүй	36.2	35.4	50.5	<b>43.0</b>
Мэдээлэл авч байгаагүй	26.1	35.5	26.6	<b>27.3</b>
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Судалгаагаар уул уурхайтай холбоотой асуудлаар иргэдтэй ямар ямар асуудлаар хэлэлцүүлэг, талуудын оролцоог хангахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлснийг тодруулахад мөн л муу үр дүн үзүүлсэн нь ихэнх хариулагчид огт зөвлөлдөж байгаагүй, мэдэхгүй хариултыг сонгож хариулснаар тайлбарлагдах юм. Тоон болон чанарын баримтуудаар уул уурхайн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоо туйлын хангалтгүй байгааг баталгаажуулсан үр дүнгүүд олонтаа дүгнэгдэж байна.

**Хүснэгт 3.5**  
Уул уурхайтай холбоотой асуудлаар иргэдтэй зөвлөлдсөн байдал(n=454)

Үзүүлэлт	Байнга	Цөөн тохиолдолд	Огт үгүй	Мэдэхгүй	Нийт
Нүүлгэн шилжүүлэлт	0.9	4.0	47.8	47.4	<b>100.0</b>
Нөхөн олговрын хэмжээ	0.7	6.8	47.6	44.9	<b>100.0</b>
Хайгуул эхлэхийн өмнө	1.3	7.0	45.2	46.7	<b>100.0</b>
А лиценз олгохын өмнө	1.1	5.3	44.7	48.9	<b>100.0</b>
А лиценз олгосны дараа	1.3	7.5	42.1	40.1	<b>100.0</b>
Уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнал	0.7	6.6	45.8	46.9	<b>100.0</b>
Уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналт	2.4	7.0	43.0	47.6	<b>100.0</b>

Цөөн тохиолдолд уул уурхайн асуудлаар иргэдтэй зөвлөлдөхдөө орон нутгийн засаг захиргаа, ОНБ, уул уурхайн ААН-ийн зүгээс уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулдаг байна.(График 3.3)



**График 3.3**  
Уул уурхайтай холбоотой асуудлаар иргэдтэй зөвлөлддөг байгууллага (N=454)



Судалгаагаар орон нутгийн иргэд, захиргаа, ОНБ-ууд уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж тодорхойлоход хэр зэрэг идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийлэх эрхээ хэрэгжүүлж байгааг шинжилсэн юм. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 0.7-22.5 хувь нь уул уурхайн БОМТ, БОННУ-ний шатны үйл ажиллагаанд оролцжээ.

**Хүснэгт 3.6**  
Уул уурхайтай үйл ажиллагаанд иргэдийн оролцооны байдал (N=454)

Үзүүлэлт	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
Уурхайг эхлүүлэхээр иргэдийн санал авах уулзалт хэлэлцүүлэгт оролцсон	35.5	12.5	13.3	22.5
Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөл, нөлөөлөлд өртөж болзошгүй хүн ам, газрыг танилцуулах уулзалтад оролцсон	12.8	4.2	5.5	8.4
Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлийн ажлыг танилцуулах уулзалтад оролцсон	5.3	2.1	2.8	3.7
БОНБУ хууль, журам дахь иргэдийн оролцоог хангахыг танилцуулах, сурталчлах уулзалтад оролцсон	3.2	4.2	4.1	3.7
Уурхайн сөрөг нөлөөллийг иргэдийн оролцоотой тогтоох уулзалтад саналаа хэлсэн	2.7	6.3	0.9	2.2
Уурхайн БОМТ-г танилцуулах, хэлэлцүүлэх уулзалтад оролцсон	2.1	4.2	2.3	2.4
Нөлөөлөлд өртсөн иргэдэд нөхөн төлбөр олгох, нүүлгэн шилжүүлэх асуудлаар зөвлөлдөх хуралд оролцсон	1.1	2.1	0.5	0.9
БОМТ-ний биелэлтийг танилцуулах уулзалтад оролцсон	3.2	2.1	0.5	1.8
Уурхайн байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн тухай орон нутгийн захиргаанд мэдээлсэн	1.1	0.0	0.5	0.7

Иргэд болон орон нутгийн захиргаа нь ашиглалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө сөрөг нөлөөллийг бууруулах эсвэл учирч

болзошгүй эрсдэл, нөлөөллийг тодорхойлоход оролцохыг хуулиар баталгаажуулсан ч судалгааны дүнгээр иргэдийн оролцоо байхгүй шахам байгааг нотолсон үр дүнгүүд гарчээ. Жишээ дурьдахад, иргэд БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах журмын 1.5-аар зохицуулсан “Менежментийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байлгана” заалтын талаар мэдээлэлгүй байгаа нь бүлгийн хэлэлцүүлгийн дүнгээр нотлогдсон юм. Эндээс дүгнэхэд тоон болон чанарын судалгааны үр дүнгээр уул уурхайн үйл ажиллагааны улмаас иргэдийн эрх ашгийг хөндсөн, байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөлтэй холбоотой асуудлаарх иргэдийн оролцоо маш сул байгааг давхар баталгаажуулсаар байна.

**Холбогдох хууль тогтоомж, журмаас:**

БОНХАЖЯ-наас 2014 онд БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах журмыг баталсан. Энэ журмын дагуу БОНХАЖЯ БОННУ хийлгэсэн төслүүдийн талаарх мэдээллийг өөрийн цахим хуудаснаа байршуулах үүрэгтэй. Уг журмын 1.5 зүйлд Менежментийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байлгана гэж заажээ.

**Стратегийн үнэлгээ:** Стратегийн үнэлгээ хийх мэргэжлийн баг нь үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтээс санал авах тухай мэдээллийг санал авч эхлэхээс өмнө олон нийтэд мэдээлж, ажлын 21 хоногт багтаан санал авах

**Хуримтлагдах үнэлгээ:** Мэргэжлийн баг нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд тухайн орон нутгийн иргэд, байгууллагаас санал авч, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах хэлэлцэх

**БОНЕУ:** Орон нутгийн захиргааны байгууллага нь тухайн орон нутагт хэрэгжих төслийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах, үнэлгээний шийдвэр, тухайн төсөлд иргэд, олон нийтээс өгсөн саналыг байгаль орчны мэдээллийн санд оруулах

**БОННУ:** Мэргэжлийн үнэлгээний байгууллага нь таамаглах үе шатанд иргэдтэй уулзалт хийх, оролцооны аргаар үнэлэх аргачлалыг ашиглан иргэдийн саналыг бүрэн авах; Нөлөөллийн үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоотой зөвлөлгөөн, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах замаар төслийн шууд болон шууд бус нөлөөллийг үнэлж, иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудлыг тусгахад анхаарах.

- Төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна. Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбогдсон саналаа тухайн баг, хорооны Иргэдийн нийтийн хуралд төслийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө хүргүүлсэн байна.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна.
- Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангаж, хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, олон нийтэд танилцуулж байна.

Уул уурхайн төсөл хэрэгжих хугацаанд уурхайн шууд болон дам нөлөөллийн бүсэд оршин суугаа иргэд хууль тогтоомжийн хүрээнд ААН, нутгийн захиргааны байгууллагаас хуулийн хүрээнд оролцох эрхээ шаардах, гомдол гаргах, шүүхэд хандах, уул уурхайн үйл ажиллагаа байгаль орчин, хүний эрүүл мэндэд нэн халтай тохиолдолд зогсоох хүртэл нь арга хэмжээ авахад иргэд оролцох эрхээ хэрэгжүүлэх нь мэдээлэлтэй байх явдал чухалчлагдаж байна.

# ДӨРӨВ. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАЛУУДЫН ОРОЛЦООГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ

Энэ бүлэгт уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах төслийн зорилгын хүрээнд орон нутгийн иргэдийн мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл хүргэх арга зам, улмаар иргэдийн оролцоог сайжруулах хувилбаруудыг судалсан үр дүнг танилцуулна.

Үнэлгээнд хамрагдсан 2 иргэн тутмын 1 нь орон нутгийн иргэдэд уул уурхайн төлөвлөлт, үйл ажиллагаа, шийдвэр гаргаж буй үйл явцад иргэдийн оролцоог хангаж хамтран ажиллах тухай сургалтын хэрэгцээ байгааг чухалчлан үзсэн байна.

➤ Хэнтий аймгийн Батширээт, Биндэр, Увс аймгийн Бөхмөрөн сумын **иргэдийн 78.8 хувь нь уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах сургалт хэрэгцээтэй** хэмээн үзэж байна.

Сумдын ялгаатайгаар шинжлэхэд, Бөхмөрөн сумын иргэдийн 89.9 хувь, Батширээт сумын иргэдийн 76.6 хувь, Биндэр сумын иргэдийн 37.5 хувь нь иргэдийг чадавхжуулах сургалт хэрэгтэй байгаагаа илэрхийлжээ.

## 4.1 ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ХҮСЧ БҮЙ МЭДЭЭЛЭЛ

### Хүснэгт 4.1

Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцооны талаарх сургалтын хэрэгцээ

Үзүүлэлт	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
Маш их хэрэгцээтэй	38.3	22.9	67.0	<b>50.4</b>
Хэрэгцээтэй	38.3	14.6	22.9	<b>28.4</b>
Хэрэгцээ бага	3.2	4.2	2.3	<b>2.9</b>
Мэдэхгүй	16.5	41.7	5.5	<b>13.9</b>
Хариулахаас татгалзсан	3.7	16.7	2.3	<b>4.4</b>
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Дээр дурьдснаар нутгийн иргэдэд мэдээллээр хангагдах хэрэгцээ өндөр байгааг судалгааны дүн харууллаа.

Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах хүрээнд нутгийн иргэд ямар мэдээлэл хүсч байгааг нээлттэй хариултын хувилбараар судалсан үр дүнг Хүснэгт 4.2-т харуулав. Иргэдийн хариултаар, иргэдийн оролцоог хангах хүрээнд олон талт мэдээлэл хүсч байгааг харж болох ба өндөр давтамжтайгаар нь эрэмбэлэн харуулбал **нэгдүгээрт**, уул уурхайтай холбоотой байгаль орчны нөлөөлөл, уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангасан хууль эрх зүйн мэдээллээр хангах, **хоёрдугаарт**, мөн энэ сэдвийн хүрээнд сургалт авах, **гуравдугаарт**, уул уурхайн байгаль орчинд учруулж буй нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлт хийх, үүнд иргэд оролцож хяналт тавихыг дэвшүүлжээ.

**Хүснэгт 4.2**  
Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах хүрээнд иргэдэд хэрэгцээтэй байгаа мэдээлэл, сумдаар

Үзүүлэлт	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
3 талт гэрээ хийх, дүгнэх, хянах, тайлагнах, хамтын ажиллагаа	2.1	0.0	4.1	<b>2.9</b>
Ажлын байраар хангах, орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулах	3.7	0.0	13.3	<b>7.9</b>
Иргэдэд үнэн зөв, нээлттэй ил тол мэдээллээр хангах \хууль, байгаль хамгаалал, оролцох эрхээ эдлэх\	26.6	8.3	11.9	<b>17.6</b>
Сургалт хийх \байгаль хамгаалал, хууль зүйн мэдлэг олгох	19.1	10.4	8.3	<b>13.0</b>
Уурхай нөхөн сэргээлт хийх, унаган төрхөд оруулахад нь иргэд хяналт хийх	3.20	6.3	17.4	<b>10.4</b>
Уурхайн ашиг, бүтээн байгуулалт, орон нутагт оруулах хувь нэмрийг мэдэх, мэдээллэх	0.5	0.0	3.2	<b>1.8</b>
Иргэдийг оролцуулсан хурал зөвлөгөөн хийх, зарыг урьдчилж хүргэх	0.0	0.0	7.8	<b>3.7</b>
Уул уурхайтай холбоотой асуудлаар гарын авлага, тараах материалаах хангах \товч, тодорхой\	0.0	0.0	2.8	<b>1.3</b>
Самбар, цахимаар иргэд болон бусад талуудад мэдээлэл хүргэх	10.6	4.2	0.5	<b>5.1</b>
Санал байхгүй	8.5	2.1	1.8	<b>4.6</b>
Мэдэхгүй	25.5	68.8	28.9	<b>31.7</b>
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

#### 4.2 ОРОН НУТГИЙН ИРГЭД, МАЛЧДАД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ, ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ

Нутгийн иргэд уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврын асуудалд ихээхэн анхаарал хандуулж, энэ талын мэдээллийг чухалчлан үзэж байна. Судалгаагаар иргэдэд хэрэгцээтэй мэдээллийг ямар арга замаар хүргэх нь иргэдийн үр дүнтэй оролцоог бий болгоход хөшүүрэг болж чадах эсэхийг шинжилсэн үр дүнг хүснэгт 4.3-т хүснэгтэд үзүүлэв.

Иргэдийн санал болгосон хувилбарт хамгийн өндөр хувьтай саналууд **нэгдүгээрт**, Уурхайн үйл ажиллагааны нээлттэй өдөрлөг талуудаас зохион байгуулдаг байх, **хоёрдугаарт**, сумын ЗДТГ, багийн самбарт уул уурхайтай холбоотой мэдээлэл тогтмол шинэчилж гаргах, **гуравдугаарт**, Уурхайтай холбоотой санал гомдлын шийдвэрлэлтийг ил тод мэдээлдэг байх хариултууд орсон байна.

**Хүснэгт 4.3**

Иргэдэд уул уурхайн мэдээллийг хүргэх арга замууд, сумдаар (Иргэдийн асуулга, N=454)


Үзүүлэлт	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
Сумын ЗДТГ, багийн самбарт мэдээлэл гаргах	41.0	37.5	35.8	<b>38.1</b>
Цахим хуудсаар мэдээлдэг байх \шинэчилдэг байх	31.9	16.7	6.4	<b>18.1</b>
Талуудын уулзалтын протоколыг самбар, уурхайн цахимд байршуулах	17.6	2.1	11.9	<b>13.2</b>
Талууд тогтмол хугацаанд сонсгол, мэдээлэл хийдэг байх	34.0	10.4	22.9	<b>26.2</b>
Уурхайн үйл ажиллагааны нээлттэй өдөрлөг талуудаас зохион байгуулдаг байх	34.6	8.3	52.4	<b>39.9</b>
Уурхайтай холбоотой санал гомдлын шийдвэрлэлтийг ил тод мэдээлдэг байх	44.1	8.3	33.9	<b>35.5</b>
Иргэдэд хурлын тов урьдчилан хүргүүлж, хурлын үр дүнг нээлттэй мэдээлдэг байх	36.7	25.0	15.1	<b>25.1</b>
Иргэдийн гэр, ажлын байранд хурал, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	24.5	18.8	15.6	<b>19.6</b>
Бусад	2.7	0.0	0.5	<b>1.3</b>
<b>Нийт</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Талууд ялангуяа уул уурхайн ААН, орон нутгийн захиргаа иргэдийн дэвшүүлсэн саналыг үйл ажиллагаандаа харгалзаж, талуудын оролцоонд суурилсан нийгмийн хариуцлагатай уулуурхайг хөгжүүлснээр иргэдийн дунд хардлага, эсэргүүцэл багасаж, байгаль орчин болон нутгийн иргэдийн аж ахуй, амьжиргаа, соёл уламжлал зэрэг иргэд болон талуудын санаа зовдог олон асуудлаар гарц, шийдлийг төслийн зорилтот үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй.

Иргэд уул уурхайн үйл ажиллагаанд оролцох сонирхол өндөр байгаа нь нийт судалгаанд оролцогчдын 70 хувь нь хариулснаас харагдаж байна. Дараах графикт иргэдийн оролцооны төлөв байдлыг сумдаар харьцуулан харууллаа.

**График 4.1**

Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах уулзалт сургалт, хэлэлцүүлэгт оролцох сонирхол (N=454)





**Шигтгээ 4.1**

Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах арга замуудын талаарх судалгаанд оролцогчдын дэвшүүлсэн санал:

Сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд иргэдийн оролцоо

- Иргэдийн гарын үсэг цуглуулах
- Уул уурхайн хор хөнөөлийг харуулсан кино үзүүлэх
- Гарын авлага, DVD айлаар тараах

Сургалт

- Иргэн ямар эрхтэйг мэдүүлэх сургалт

Уул уурхайн бус орлогыг сурталчлах

- Цэвэр агаар-экотуризм
- Сүү цагаан идээ, жимс, самараа ашиглах
- Амар амгалан амьдрал

Иргэдийн оролцоог дэмжих, зохион байгуулах үйл ажиллагаа

- Асуудлаа мэддэг, иргэдийг төлөөлсөн ТББ байх: иргэддээ эргэх холбоотой мэдээлэл хүргэдэг
- Шударга ажиллах
- Иргэдийг уул уурхайн үйл ажиллагаанд төлөөлдөг байх
- Ойн нөхөрлөлийг ашиглан сургалт авах
- Хууль эрх зүйн талаас Онон Улс ТББ-тай хамтран ажиллах
- Уул уурхай сум орон нутгийн захиргаа, иргэдтэй гэрээ хийдэг байх
- Уул уурхайн ТЭЗҮ, БОННУ, гэрээг ил тод мэдээлэх

Иргэдийг мэдээллээр хангах хүрээнд:

- БОУБ \БОМТ-ийн төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, БОННУ, газрын зөвшөөрөл г.м\
- ИТХ-ын ажлын алба
- Ойн нөхөрлөл
- Эмэгтэйчүүдийн ТББ

*(Хэнтий аймаг, Батширээт сум, холимог бүлгийн хэлэлцүүлэг)*

Бүлгийн хэлэлцүүлгийн үеэр уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангахад чиглэсэн саналуудыг багцлан дараах матрицаар харууллаа.

**Матриц 4.1**

Иргэдийн оролцоог хангахад чиглэсэн үйл ажиллагааны талаарх иргэдийн санал (Чанарын судалгааны дүн шинжилгээ)

Хэнтий аймаг	Увс аймаг
<ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчноо хамгаалах сургалтад хамрагдах</li> <li>• Талуудын хамтын ажиллагааг бий болгох</li> <li>• Үнэн зөв бодит мэдээллээр хангагдах</li> <li>• ИНБ, сүлжээний зохион байгуулалтаар ажиллах, суманд байгаа сүлжээг БО-ны нөхөрлөл, ТББ ашиглах</li> <li>• Иргэдэд зориулсан мэдээллийн нээлттэй самбар ажиллуулах</li> <li>• Нутгийн иргэдийг ажлын байраар хангах</li> <li>• Уул уурхайн талаарх иргэдийн оролцоо оролцооны хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт</li> <li>• Баг, орон нутгийн захиргаа уул уурхайн талаарх мэдээллээ ил тод болгох</li> <li>• 3 талт гэрээ байгуулах</li> <li>• Уулзалт хурлын зарыг эртнээс явуулах</li> <li>• Иргэд үгээ хэлдэг байх</li> <li>• Орон нутгийн захиргаа намчирхаж асуудалд ханддаг, иргэдийн төлөө ажилладаггүй</li> <li>• Бүх багийн иргэдэд мэдлэг мэдээлэл олгох \ганц багийн асуудал биш</li> <li>• Идэвхтэн байгаль хамгаалагч нартай хамтран ажиллах</li> <li>• Иргэд, малчдын фасебүүкээр дамжуулж мэдээлэл хүргэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хамтын ажиллаганы 3 талт гэрээний хяналт, дүгнэлтийг иргэд хийдэг байх.</li> <li>• Уул уурхайн БОННУ шилэн байх, талуудад нээлттэй байх</li> <li>• Иргэдийн оролцоог хангасан мөн байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг татан оролцуулдаг байх</li> <li>• Үнэн зөв мэдээллээр хангагддаг болох</li> <li>• Залуучуудыг мэдээлэлээр хангах, тэдний идэвхи оролцоог нэмэгдүүлэх</li> <li>• Уул уурхайн ААН нь нээлттэй өдөрлөг зохион байгуулдаг байх</li> <li>• Багийн хурлаар уурхайгаас тогтмол мэдээлэл хийдэг байх</li> <li>• Уурхай нөхөрлөлийн гишүүдтэй нягт хамтран ажилладаг байх</li> </ul>

Орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийн зүгээс уул уурхайн үйл ажиллагааны мөчлөгт иргэдтэй хэрхэн харилцаж, ямар арга замаар хамтран ажиллахыг илүүд үзснийг хүснэгт 4.4-т үзүүлэв.

**Хүснэгт 4.4**

Уул уурхайн шийдвэр гаргалтад талуудын оролцоог хангах төслөөс хүлээж буй хүлээлт (Орон нутгийн удирдлага, мэргэжилтэн N=71)


Хариултын хувилбар	Батширээт	Биндэр	Бөхмөрөн	Нийт
Ажлын байраар хангах	7.7	20.0	0.0	<b>11.3</b>
Хуулийн хүрээнд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх	34.6	20.0	26.7	<b>26.8</b>
3 талт гэрээ хийх, хамтын шийдвэр гаргах	0.0	3.3	13.3	<b>4.2</b>
Иргэдэд уул уурхайн талаар үнэн зөв мэдээлэл ойлголт тогтмол өгөх	19.2	3.3	6.7	<b>9.9</b>
Иргэдийн оролцоонд тулгуурлаж шийдвэр гаргах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх	19.2	30.0	6.7	<b>21.1</b>
Олон лиценз олгохгүй байх	0.0	3.3	6.7	<b>2.8</b>
Бусад /хурал зөвлөгөөн	0.0	3.3	26.7	<b>7.0</b>
Мэдэхгүй	19.2	16.7	13.3	<b>16.9</b>
Нийт	100.0	100.0	100.0	<b>100.0</b>

Орон нутгийн захиргааны удирдлага, мэргэжилтнүүдийн 26.8 хувь нь хуулийн хүрээнд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, 21.1 хувь нь иргэдийн оролцоонд тулгуурласан шийдвэр гаргах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх саналуудыг гаргасан нь ирээдүйд уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоо нэмэгдэх боломжтойг харуулж байна. Түүнчлэн иргэд уул уурхайн талаарх мэдлэг чадвартай болох саналуудыг түлхүү дэвшүүлсэн нь орон нутгийн удирдлага ба иргэн аль аль нь талуудын оролцоонд суурилсан хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилгод нэгдэж байгааг судалгааны дүн харуулж байна.

### 4.3 УУЛ УУРХАЙН КОМПАНИЙН БАЙР СУУРЬ

Зөвлөх баг төсөл хэрэгжихээр сонгогдсон газруудад уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 6 ААН, болон Хэнтий, Увс аймагт хайгуулын тусгай зөвшөөрөл авсан нийт 17 ААН-ийн удирдлагатай уулзаж тэдний байр суурь, санаа бодлыг судалгааны тайланд тусгалаа. ААН-ийн удирдлагууд уул уурхайн үйл ажиллагаанд талуудын тэнцвэртэй оролцоог хангах хууль тогтоомж, тушаал шийдвэрийн талаар 47 хувь нь ерөнхий мэдээлэлтэй, 12 хувь нь бага зэргийн мэдээлэлтэй байна.

**График 4.2**  
Уул уурхайн үйл ажиллагаанд талуудын тэнцвэртэй оролцоог хангах хууль тогтоомж, тушаал шийдвэрийн талаарх мэдээлэлтэй байдал



Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулахад гардаг хүндрэл бэрхшээлтэй асуудлын талаар өгсөн мэдээллийг багцлан дараах байдлаар үзүүлж байна. Үүнд:

- Иргэд мэдээлэл хангалтгүйгээс цуу ярианд тулгуурлан ААН-д үндэслэлгүй, боломжгүй шаардлага тавьж, эсэргүүцдэг.
- Иргэдийн зүгээс сөрөг хандлага гаргаж үйл ажиллагаа явуулахад саад учруулдаг.
- Уурхайн үйл ажиллагаанд төлөвлөгдөөгүй, төсөвлөгдөөгүй санхүүгийн дэмжлэг хүсдэг
- Иргэд, малчид геологийн судалгааг уул уурхайн үйл ажиллагаатай хольж ойлгодгоос эсэргүүцэл түгээмэл гардаг
- Уул уурхайн талаарх төрийн төв байгууллага, орон нутгийн удирдлагын нэгдсэн бодлого, хэрэгжилтын зөрүүгээс үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулдаг
- Орон нутгийн иргэдтэй тууштай ойлголцолд хүрч чаддаггүй
- Шат шатны удирдлагын хүнд суртал ажилд хүндрэлтэй
- Улс төрийн тогтворгүй байдал уурхайн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг

- Уурхайн БОННУ батлуулахад багийн ИНХ-аас тогтоол зөвшөөрөл авах нь хамгийн хүндрэлтэй асуудал \Баг, сумын иргэдтэй ойлголцох хамгийн хүнд\
- Нүүрсний олборлолтын ААН-дийн хувьд зах зээлийн багтаамж бага, өрсөлдөөн ихээс үнэ унадаг, дэд бүтэц муу хөгжсөн

**Шигтгээ 4.1**

ААНБ бид хууль, журмын дагуу тусгай зөвшөөрөлтэйгээр ажиллаж байхад сум орон нутгагтай үл ойлголцох асуудлууд гардаг. Сум орон нутгийн удирдлагууд уул уурхайн талаар нэгдсэн нэг журам баримталж ажилламаар байна. Орон нутгийн удирдлагууд амбиц гаргах эсвэл улс төржүүлэх, хэн нэг малчны дургүйцлээс болоод олон жил зүтгэсэн ААН-ийн хэвийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж хүндрэл учруулдаг.

(Ганцаарчилсан ярилцлага, уул уурхайн төлөөлөл)

**Хүснэгт 4.5**

Орон нутагт уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААН дараах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулж хамтран ажилласан туршлага, хувиар

Үзүүлэлт	Ганц нэг удаа	Цөөн тохиолдол	Огт үгүй	Нийт
Уул уурхайн үйл ажиллагаа эхлүүлэх танилцуулга	41.1	35.4	23.5	100.0
Уурхайн үйл ажиллагааны хүн ам, бэлчээр, байгалийн нөөцөд учруулах нөлөөлөл	24.0	6.0	70.0	100.0
БОМТ, түүний тайлагнал	29.4	17.6	53.0	100.0
БОННУ	53.0	17.6	29.4	100.0
Нөхөн сэргээлт	47.0	6.0	47.0	100.0
Нүүлгэн шилжүүлэлт	6.0	6.0	88.0	100.0
Нөхөн олговор	0.0	6.0	94.0	100.0
Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлт	29.4	17.6	53.0	100.0
Иргэд, малчидтай хамтран ажиллах үйл ажиллагааны танилцуулга	29.4	17.6	53.0	100.0

Уул уурхайн аж ахуйн нэгжийн төлөөллийн 41 хувь нь талуудын тэнцвэртэй оролцоог хангах мэдлэгээ сайн гэж үнэлсэн ч уул уурхайн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж ажилласан туршлага хангалтгүй төвшинд байгааг хүснэгт 4.5-т харуулсан үр дүн харуулж байна.

ААН-үүд уул уурхайн үйл ажиллагаанд талуудын тэнцвэртэй оролцоог хангахад чиглэсэн дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Сум, багийн ЗД, иргэд малчдад уул уурхайн үйл ажиллагааны талаарх ойлголт, мэдээллийг өгч, асуудлаа тайлбарлаж ойлгуулахад анхаарах, уул уурхайн компаниудыг мөнгөтэй баян байгууллага гэж хандах нь иргэдийн дунд тогтсон.
- Уул уурхайн үйл ажиллагаа эхлэхдээ бүх талуудтай хамтран ажиллах шаардлагатай. Ялангуяа сум, орон нутгийн удирдлагын түвшинд хамтын ажиллагааны гэрээг сайтар зөвшилцөн байгуулах шаардлагатай байгаа нь хайгуулын

шатанд ашигт малтмалын нөөц, илэрц тодорхойгүйгээс шалтгаалж орон нутагтай байгуулах хамтын ажиллагааны гэрээгээр зохицуулагдах хөрөнгө оруулалтыг багаар тооцох сонирхолтойгоо илэрхийлсэн. Ашиглалтын шатанд сум орон нутагтай зөвшилцөн хамтын ажиллагааны гэрээнд боломжит хөрөнгө нөөцийг тусгах боломж бий.

- Нөлөөллийн бүсэд нутагладаг иргэд, малчидтай олон удаагийн уулзалт хэлэлцүүлэг хийх, мэдээлэл ил тод, нээлттэй тавих, үнэн зөв мэдээлэл өгөх,
- Сум орон нутгийн удирдлага ААН-тэй нээлттэй, хамтран ажилладаг байх,
- Бүх талуудтай харилцан ойлголцдог байх,
- Иргэд болон талуудад хуулийн хүрээний мэдээллээр хангах,
- Сум орон нутгийн удирдлагын зүгээс нутгийн иргэд малчдад зөв мэдээлэл, чиглэлийг өгч харилцааг сайжруулах,
- Орон нутгийн захиргаа, иргэдийн зүгээс ААН-ийг зөв ойлгож дэмжиж ажиллавал уул уурхайн үйл ажиллагаа хэвийн явагдаж, алдагдал бага хүлээнэ, богино хугацаанд орон нутгийн хөгжилд үр ашиг, өгөөжөө өгөх боломжтой,

Дээрхээс дүгнэхэд уул уурхайн удирдлагууд уул уурхайн шийдвэр гаргалтад талуудын тэнцвэртэй оролцоог хангах сонирхолтой байгаа нь ажиглагдсан тул сум орон нутгийн удирдлага мэдлэг мэдээллээ нэмэгдүүлж, хамтын ажиллагаа, уялдаа холбоогоо сайжруулж үр ашигтай менежментийг манлайлан ажиллах шаардлагатай байна.



## ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ

“Мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх” судалгаанд Хэнтий, Увс аймгийн 454 иргэн, 71 төрийн албан хаагчид нийт 525 хүн амыг хамруулж тоон (асуулга) болон чанарын (ганцаарчилсан, фокус бүлгийн хэлэлцүүлэг) судалгааны аргаар мэдээлэл цуглуулан, дүн шинжилгээ хийж нэгтгэн дүгнэлээ. Энэхүү судалгааны үр дүнд талуудыг мэдээллээр хангах, тэнцвэртэй оролцоог бий болгож, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар дараах дүгнэлт, зөвлөмжийг хийлээ. Үүнд:

- Орон нутгийн иргэд телевиз, ам дамжсан ярианаас, төрийн албан хаагчид орон нутгийн захиргааны байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон ААН-ээс мэдээлэл авч байгааг асуулга судалгааны үр дүн харуулж байна. Иргэд болон орон нутгийн захиргааны хаагчдын авч буй мэдээллийн найдвартай, баталгаатай байдал ялгаатай улмаар талуудын авч буй мэдээллийн найдвартай байдал, мэдээллийн тэнцвэртэй байдал ялгаатай байна хэмээн дүгнэж байна.
- Орон нутгийн захиргааны байгууллага хуулиар олгогдсон чиг үүргийн дагуу иргэдэд орон нутагт хэрэгжиж буй уул уурхайн төслийн холбогдох мэдээллийг нээлттэй байлгах үүрэг хүлээдэг ч хэрэгжилт хангалтгүй байгааг тоон болон чанарын судалгааны дүн харуулж байна. Үүний нэг шалтгаан нь албан хаагчид ААН-ээс уул уурхайн үйл ажиллагааны талаарх мэдээлэл авч хэвшээгүйтэй холбоотой юм.
- Судалгаанд оролцсон иргэдийн 75.2 хувь, нутгийн захиргааны албан хаагчдын 15.5 хувь нь уул уурхайн талаар хангалтгүй мэдээлэлтэй байгаа нь орон нутагт хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нэгдсэн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, үйл ажиллагаа хангалтгүй хэрэгжиж ирсэнтэй холбоотой байна. Түүнчлэн захиргааны албан хаагчид иргэдээс ирсэн санал, гомдлоос уул уурхайн талаарх мэдээлэл зохих хэмжээнд авч байгаа сонирхолтой дүн судалгаагаар ажиглагдсан.
- Иргэдийн хувьд уурхайн үйл ажиллагааны мэдээллийг нээлттэй өдөрлөг зохион байгуулах хэлбэрээр авахыг 52.4 хувь, сумын ЗДТГ болон багийн төвийн мэдээллийн самбараар 35.8 хувь нь санал болгожээ. Мөн уурхайтай холбоотой санал гомдлын шийдвэрлэлтийг мэдээлдэг тогтолцоог бий болгох хэлбэрээр мэдээллээ авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.
- Иргэдийн хамгийн их сонирхож, ил болгохыг шаарддаг мэдээлэл бол ашигт малтмалын нөөц, ААН-ийн ашиг орлого, орон нутагт оруулах хувь нэмэр зэрэг асуудлууд бөгөөд эдгээр мэдээллийн ил тод нээлттэй байдал хангагдахгүй байгаагаас нутгийн иргэд болон ААН-ийн хооронд зөрчил байсаар байна.

- Увс, Хэнтий аймагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдэд олон нийттэй харилцах бүтэц бий болоогүй тул талуудын тэнцвэртэй оролцоог хангах, хамтран ажиллах явдал сул байгааг чанарын судалгааны үр дүн харуулсан.
- Судалгаанд хамрагдсан 2 иргэн тутмын 1 нь уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах талаар ойлголцогүй байгаа нь судалгаагаар дүгнэгдсэн тул иргэдэд чиглэсэн үр нөлөөтэй сурталчилгаа, мэдээллийн хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Орон нутгийн удирдлага нь ААН-тэй ашиг сонирхол нэгддэг, уул уурхайн асуудлаар иргэдэд зөв мэдээлэл өгч шударга ажилладаггүй, уул уурхайн асуудлаарх хуулиар олгогдсон үүргээ хангалттай судлаагүйд иргэд шүүмжлэлттэй хандсныг чанарын судалгаа дүн харуулж байна.
- Судалгааны үр дүнгээр, уурхайн талаарх мэдээллийг иргэд найдваргүй, баталгаагүй эх үүсвэрээс авч байгаа тул иргэдэд тогтмол бодитой мэдээллийг орон нутгийн захиргааны албан хаагчид хүртээмжтэй хүргэж ажиллах шаардлага байна.
- Иргэдийн зүгээс ААН-д итгэх итгэлийг сулруулахад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:
  - ААН болон орон нутгийн захиргаа нь уул уурхайн үйл ажиллагаанаас нутгийн иргэдийн амьжиргаа, зан заншил, соёл уламжлалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байлгахад анхаарал хандуулдаггүй байдал,
  - Уурхайн байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн тухай бодит мэдээллийг иргэдэд танилцуулдаггүй байдал,
  - Уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд иргэдийг оролцуулдаггүй байдал,

Тиймээс дээрх хүчин зүйлсийн анхаарч ажиллах бодит шаардлага ААН-үүдэд байна.

- Уул уурхайн ААН тухайн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахаас өмнө орон нутгийн иргэдтэй харилцан ойлголцож, зөвлөлддөггүйгээс маргаан, эсэргүүцэл гарсаар байна. ААН тухайн бүс нутагт хэрэгжүүлэх уул уурхайн төслийн орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, ач холбогдлыг иргэдэд тайлбарлан таниулдаггүй бөгөөд зөвхөн ААН ба нутгийн захиргааны байгууллагын хооронд асуудал шийдэгддэг. Тэдний хэлэлцсэн асуудал, шийдвэр ил тод биш, иргэдийг оролцоог хангадаггүй хэмээн бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон иргэд, ОНБ-ын төлөөлөл үзсэн юм.
- Судалгаанд хамрагдсан иргэдийн 41 хувь нь байгаль хамгаалах, аргаль хамгаалах нөхөрлөл болон малчдын бүлгийн гишүүнээр ажилладаг гэж хариулсан бол албан хаагчдын 76 хувь нь нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалах нөхөрлөл,

бэлчээр хамгаалдаг малчдын бүлэгтэй гэж хариулсан нь уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах хангалттай хөрс суурь байгааг харуулж байна.

- Уул уурхайн шийдвэр гаргалтад талуудын тэнцвэртэй оролцоог хангахад орон нутгийн захиргааны байгууллага, ОНБ, ААН нь чухал үүрэгтэйг талууд судалгаагаар онцлон илэрхийлж байна. Иймд талуудын харилцаа холбоо, уялдаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд орон нутгийн захиргаа зөв чиглүүлж өгөх нь зүйтэй байна.
- Уул уурхайн асуудлаар талуудыг иргэдтэй зөвлөлддөггүй гэж иргэдийн 65 хувь нь үзсэн нь хамгийн өндөр хувийн жин эзэлсэн байна. Харин нутгийн захиргааны албан хаагчид 22 хувь, ОНБ 9 хувь, ААН 4 хувь нь тус тус иргэдтэй зөвлөлддөг гэж хариулснаас үзвэл талуудын иргэдтэй зөвшилцөх үйл ажиллагааг эрс сайжруулах хэрэгцээ байгааг харуулж байна.
- Иргэд болон нутгийн захиргааны байгууллага нь ашиглалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө сөрөг нөлөөлөл, болзошгүй эрсдэлийг тодорхойлоход оролцох журамтай ч ялангуяа иргэдийн оролцоо маш бага төдийгүй “менежментийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байлгана” гэсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмын заалтын талаар оролцогч талууд мэдэхгүйгээс энэхүү хууль журам хэрэгжилт хангалтгүй байна.
- Орон нутгийн захиргааны удирдлага, мэргэжилтнүүдийн 26.8 хувь нь хуулийн хүрээнд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, 21.1 хувь нь иргэдийн оролцоонд тулгуурласан шийдвэр гаргах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх саналуудыг гаргаснаас үзвэл цаашид уул уул шийдвэр гаргалтад иргэдийн оролцоо нэмэгдэх боломж байна.
- Иргэд, орон нутгийн захиргааны байгууллага нь уул уурхайн шийдвэр гаргалтад оролцохдоо ялангуяа Хамтын ажиллагааны гэрээ, БОМТ болон БОННУ-г боловсруулахад оролцох, саналаа хэлэх, үнэлэх, хянах, дүгнэхэд идэвхтэй тогтвортой оролцоог хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох шаардлага байна.
- Иргэдийн саналыг сонсох, тэдэнтэй уулзалт, хэлэлцүүлэг өрнүүлж, зөвлөлдөж байх, хууль, эрх зүйн мөн оролцооны сэдвээр сургалтанд хамруулснаар уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоо хангагдана гэж судалгаанд оролцогчид үзэж байна.
- Орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа чадавхжсан ОНБ цөөн байна. Сумын төвшинд иргэд, малчдын 41 хувь нь байгаль хамгаалах, бэлчээр хамгаалах нөхөрлөлийн гишүүнээр үр дүнтэй ажиллаж байгаа суурь институцлэгдсэн бүтэц бий болсон байна. Иймд уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэхэд эдгээр нөхөрлөлүүд болох ОНБ-уудаар дамжуулж бусад иргэдэд хүрч ажиллах нь илүү үр дүнтэй байна.

- Судалгааны дүнгээр уурхайн БОМТ, БОННУ дэх иргэдийн оролцоо сул, иргэд уурхайтай холбоотой асуудлаарх хууль эрх зүйн сургалтанд хамрах хэрэгцээ өндөр гарсан тул уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоо, мэдээлэлтэй байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сурталчилгаа, мэдээллийг системтэй, тогтмол боломжит арга замуудаар хүргэх нь чухал байна.
- Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлтэй холбоотой асуудлаар иргэдээс ирүүлсэн санал шүүмжлэл, гомдол, өргөдөлд хуулийн хүрээнд хариу арга хэмжээ авч, энэ талын мэдээллийг бүх оролцогч талуудад ил тод, нээлттэй мэдээллэдэг байхыг иргэд санал болгосон. Иймд нутгийн захиргааны байгууллага энэ асуудлын хүрээнд анхаарч ажиллах шаардлагатай байна.
- ААН-үүдийн удирдлага, ажиллагсдад талуудын тэнцвэртэй оролцоог хангах тухай хууль, эрх зүйн мэдлэг, мэдээллийг олгох сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгцээтэй байна. Түүнчлэн ААН нь орон нутгийн уул уурхайн талаар баримталж буй бодлогыг дэмжиж хамтран ажиллах шаардлагатай.
- ААН-ээс иргэд мэдээллийг ил тод, нээлттэй байлгахыг шаарддаг. Тиймээс ААН-ийн зүгээс хэрэгцээт мэдээллүүдийг талуудад хуулийн хүрээнд тогтмол мэдээлэх, тайлагнах, зөв ойлголт өгч, харилцаа, хамтын ажиллагаа, уялдаа холбоогоо сайжруулах шаардлагатай юм.

## 1. АСУУЛГЫН ХУУДАС (ИРГЭД, МАЛЧИД)

Дэлхийн байгаль хамгаалах сан, Ногоон хөгжлийн хөтөч ТББ-ийн зөвлөх баг хамтран “Уул уурхайн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар Монгол орны ард иргэдийн болон мал сүргийн эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх ба байгаль орчныг хамгаалах нь” төслийн хүрээнд Батширээт сумын иргэд, малчдын уул уурхайн шийдвэр гаргалтад оролцох оролцоог тодорхойлох мэдлэг, хандлага, дадал (KAP survey) судалгааг явуулж байна. Таны хариулт уул уурхайд иргэдийн оролцоог хангах нөлөөллийн хөтөлбөрийг боловсруулахад хувь нэмрээ оруулна. Зөв, буруу хариулт байхгүй, Та өөрийн санаа бодолтой тохирох хариултыг сонгох, саналаа хуваалцана уу.

### Хяналтын хэсэг

	Нэр	Код
Сумын нэр		
Багийн нэр		
Судалгаанд оролцогчийн утас		

Судалгаа авсан				
Он				
Сар				
Өдөр				

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Таны нас [.....]
2. Хүйс 1. Эмэгтэй 2. Эрэгтэй
3. Боловсрол
  1. Дээд
  2. Тусгай дунд
  3. Бүрэн дунд
  4. Бүрэн бус дунд
  5. Бага
5. Ажил эрхлэлт
  1. Төрийн байгууллагад
  2. Хувийн хэвшлийн байгууллагад
  3. Хувиараа хөдөлмөр эрхэлдэг
  4. Тэтгэвэр тэтгэмжид
  5. Малчин
  6. Тариаланч, ногоочин
  7. Ажилгүй
  8. Бусад (бичнэ үү).....
6. Танай өрхийн орлогын эх үүсвэрүүд
  1. Цалин
  2. МАА
  3. Тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгө
  4. Үр тариа, газар тариалан
  5. Төмс, хүнсний ногоо ханган нийлүүлснээс
  6. Жимс, самар, эмийн ургамал г.м дагалдах баялаг



7. Мод, түлээ түлшний мод бэлтгэл
8. Хувиараа хөдөлмөр эрхэлснээс
9. Уул уурхайд ажил эрхлэснээс
10. Уул уурхайд бүтээгдэхүүн
11. Бусад.....

7. Танай өрхийн сарын дундаж орлого .....төгрөг

8. Танай өрх уул уурхайн лизенз олгогдсон талбайгаас хэдэн км зайд нутаглаж байна?.....

9. Таны гишүүнчлэл?

1. Эмэгтэйчүүдийн ТББ-ын гишүүн
2. Ойн нөхөрлөлийн гишүүн
3. Загасны клубийн гишүүн
4. ТББ-ын гишүүн.....ТББ-ын нэрээ бичнэ үү?
6. Малчдын бүлэг, бэлчээр ашиглагчдын хэсгийн гишүүн
7. Бусад.....бичнэ үү?
8. Гишүүнчлэл байхгүй

## II. ИРГЭД, МАЛЧДЫН УУЛ УУРХАЙН МЭДЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ТҮВШИН, ХАНДЛАГА

10. Та уул уурхайтай холбоотой мэдээллийг ямар эх үүсвэрээс авч байна? Ихэвчлэн авдаг 3 эх үүсвэрээ сонгоно уу?

1. Телевиз
2. Орон нутгийн ТВ
3. Радио
4. Өдөр тутмын сонин
5. Шар сонин
6. Уул уурхайн ААН
7. Багийн хурал
8. Сум, ИТХ-ын хурал
9. Орон нутгийн удирдлага, мэргэжилтэн
10. ИНБ, ТББ, нөхөрлөл, клуб
11. Тойргийн УИХ
12. Олон улсын төсөл хөтөлбөрийн хурал уулзалт, тараах материал
13. Нутгийн иргэдийн ам дамжсан яриа
14. Гэр бүлийн гишүүдээс
15. Найз нөхөд
16. Цахим мэдээллийн хуудас, фасебүүк г.м
17. Гарын авлага, тараах материал
18. Самбар
19. Бусад.....бичнэ үү?

11. Та уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хэр мэдээлэлтэй байна?

	Хангалттай их	Ерөнхий мэдээлэлтэй	Бага, мэдээлэлгүй
Нутаг дэвсгэрийн аль хэсэгт лицензтэй	1	2	99
Ямар ямар уул уурхайн ААН байгаа тухай	1	2	99
Уурхайн техник эдийн засгийн үндэслэл	1	2	99
Уурхайн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	1	2	99
Нөхөн сэргээлт			
Уул уурхайгаас үүдэлтэй хүний эрхийн зөрчил	1	2	99
Уурхайн хууль зөрчсөн үйлдэл	1	2	99
Тусгай зөвшөөрөл авахад иргэдийн оролцоо	1	2	99
Тусгай зөвшөөрөл олгосны дараа иргэдийн оролцоо	1	2	99
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд иргэд, орон нутгийн удирдлагын саналыг авах тухай	1	2	99
Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор	1	2	99
Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд танилцуулах тухай	1	2	99
Бусад			

12. Та уул уурхайн ААН удын талаар хэр мэдээлэлтэй байна вэ?

1. Хангалттай сайн мэдээлэлтэй
2. Ерөнхий мэдээлэлтэй
3. Хангалтгүй мэдээлэлтэй
4. Бараг мэдээлэлгүй

13. Та орон нутгийн байгаль орчныг байдлыг ямар байна гэж үнэлж байна?

1. Хэвэндээ
2. Доройтсон
3. Мэдэхгүй байна

14. Уул уурхайн ААН уд байгаль орчин, байгалийн нөөцүүдэд ямар нөлөө үзүүлж байна вэ?

	Маш их сөрөг	Сөрөг нөлөө бага	Сөрөг нөлөө байхгүй	Мэдэхгүй
Бэлчээр	1	2	3	99
Газрын хөрс	1	2	3	99
Ус, усны нөөц	1	2	3	99
Ургамал, ургамлын төрөл зүйл	1	2	3	99

Ан амьтан	1	2	3	99
Агаар	1	2	3	99
Ой сан	1	2	3	99
Газрын доорх болон дээрх баялаг	1	2	3	99
Нөлөөллийн бүсийн байгаль орчин	1	2	3	99

15. Уул уурхай байгаль орчин, орон нутгийн иргэдийн амьжиргаанд ямар өөрчлөлт үзүүлж байна?

	Маш их сөрөг	Сөрөг нөлөө бага	Сөрөг нөлөө байхгүй	Мэдэхгүй
Гүний болон гадаргын ус	1	2	3	99
Булаг шанд	1	2	3	99
Хөрс	1	2	3	99
Газар хөрс	1	2	3	99
Хүн мал амьтан нүхэнд унаж осолдсон гэмтэх	1	2	3	99
Ан амьтад	1	2	3	99
Зэрлэг ховор ан амьтан	1	2	3	99
Бэлчээрийн талбай	1	2	3	99
Ой	1	2	3	99
Чичиргээ дуу чимээ	1	2	3	99
Голын гольдрил	1	2	3	99
Гол усны бохирдол	1	2	3	99
Уурхайн хог хаягдал	1	2	3	99
Химийн бодисын хэрэглээ	1	2	3	99
Ургамлын төрөл зүйл	1	2	3	99
Олон салаа зам	1	2	3	99
Тээврийн хөдөлгөөн, замын ачаалал	1	2	3	99
Нөлөөлийн орчны бүс	1	2	3	99
Хүн малын эрүүл мэнд	1	2	3	99
Дуу чимээ, гэрлийн нөлөөгөөр хүн малд	1	2	3	99
4 улирлын нүүдэл	1	2	3	99
Өвөлжөө хаваржааны газар	1	2	3	99
Хадлангийн талбай	1	2	3	99
Ногоо, тариалангийн талбай	1	2	3	99
Бэлчээрийн талбай шахагдахад	1	2	3	99
Бусад	1	2	3	99

16. Дээрх тохиолдолд Та хэнд хандаж байсан бэ?

1. Багийн засаг дарга
2. Аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагад
3. Сумын засаг дарга, ИТХ-ын тэргүүлэгчдэд
4. Байгаль орчны улсын байцаагч
5. Идэвхтэн байгаль хамгаалагч
6. Ойн нөхөрлөлийн ахлагч/гишүүд
7. ИНБ, ТББ-т.....нэрийг нь бичнэ үү?
8. Уул уурхайн ААН д
9. Цагдаад
10. Тойргийн УИХ-ын гишүүнд
11. Хандаад нэмэргүй
12. Хандаж байгаагүй
13. Хэнд хандахаа мэдэхгүй байсан

17. Дээрх байгууллага, албан тушаалтнаас ямар арга хэмжээ авсан бэ?

.....

18. Та болон танай нутгийнхан байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжүүлдэг туршлагаасаа хэлж өгнө үү?

1. Ой, байгаль хамгаалах нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын бүлгийн гишүүнээр ажилладаг
2. Идэвхтэн байгаль хамгаалагчаар ажилладаг
3. Булаг шандын эх хашдаг
4. Хулгайн анчид, самар жимсчдийг хөөдөг, орон нутгийн удирдлагад мэдээлдэг
5. Хууль бус мод бэлтгэгчидтэй тэмцдэг
6. Уул уурхайн хууль бус үйл ажиллагаатай газар дээр нь хэлж эсэргүүцдэг
7. Иргэдэд байгаль хамгаалах, экологийн боловсрол олгох чиглэлээр ТББ, ОНБ байгуулан ажилладаг
8. Ой, байгаль хамгаалах чиглэлээр нөхөрлөл, бүлэг байгуулан сум, багийн ЗД-тай гэрээтэй ажилладаг
9. Ой, байгалийн нөөцөд ямар нэгэн сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг ажиглаж байдаг, мэдээлдэг
10. Бусад.....бичнэ үү?

19. Таны байгаль хамгаалах үүсгэл санаачлагыг хэн хамгийн их дэмждэг вэ?

1. Нутгийн малчид, иргэд
2. Нутгийн ИНБ, ТББ
3. Нутгийн ойн нөхөрлөл
4. Хамтран ажилладаг ОУБ, төсөл хөтөлбөр
5. Сум, багийн ЗД, ИТХ
6. Мэргэжлийн байгууллага \БОУБ г.м\
7. Уул уурхайн ААН
8. Хэн ч дэмждэггүй

20. Танай нутагт иргэд, малчдыг төлөөлсөн дараах ИНБ, ТББ, нөхөрлөл, бүлэг байна уу?

1. Ойн нөхөрлөл
2. Малчдын бүлэг, бэлчээр ашиглагчдын бүлэг
3. Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага
4. Загасчдын клуб ТББ
5. Эко клуб
6. ТББ.....бичнэ үү?
7. Бусад.....бичнэ үү?

21. Уул уурхайн ААН , орон нутгийн захиргааны байгууллага дараах асуудлаар Таньтай уулзаж тохиролцож байсан уу?

	Байнга зөвлөлддөг	Ганц нэг удаа зөвлөлдсөн	Огт үгүй	Мэдэхгүй
Нүүлгэн шилжүүлэлт	1	2	3	99
Нөхөн олговрын хэмжээ тогтоох	1	2	3	99
Хайгуул хийхийн өмнө	1	2	3	99
Ашиглалтын лиценз олгохын өмнө	1	2	3	99
Ашиглалтын лиценз олгосны дараа	1	2	3	99
Иргэд малчдын амьжиргаа, амьдралын орчин	1	2	3	99
Уул уурхайн төлөвлөлт, тайлан	1	2	3	99
Уул уурхай дахь иргэд, малчдын хяналт, оролцоо	1	2	3	99

22. Дээрх үйл ажиллагааг уул уурхай, орон нутгийн захиргааны байгууллагын аль нь зохион байгуулагддаг вэ?

1. Орон нутгийн захиргаа
2. Уул уурхай
3. ИНБ, иргэдийн хөдөлгөөн, ТББ
4. Мэдэхгүй

23. Жилд хэдэн удаа иргэдийг оролцуулсан уулзалт хэлэлцүүлэг, танилцуулга хийдэг вэ?

1. Долоо хоног бүр
2. Сард 1-2 удаа
3. Улиралд 1 удаа
4. Хагас жилд 1 удаа
5. Жилдээ нэг удаа
6. Мэдэхгүй

24. Уул уурхайн ААН ас иргэд малчидтай ямар хэлбэрээр хамтран ажилладаг вэ?

1. Хуралд урьж оролцуулдаг

2. Айл өрхүүдээр зочилж мэдээлэл өгдөг
3. Саналыг харгалзаж шийдвэр гаргадаг
4. Бичгээр санал хүсэлт авдаг
5. Үйл ажиллагаандаа байнга оролцуулдаг
6. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхөн сэргээлт хэрхэн хийж байгаагаа үзүүлдэг, мэдээлдэг
7. Бусад.....бичнэ үү?

25. Уул уурхайн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах гэж юуг хэлж байна вэ?

.....

26. Уул уурхайд иргэдийн дуу хоолойг сонсох, хамтран ажиллах хурал уулзалт, сургалтанд хамрагдаж байсан уу?

1. Нэг удаа
2. Хоёр удаа
3. 3 удаа
4. 4 удаа
5. 5-аас дээш удаа
6. Огт оролцож байгаагүй
7. Уулзалт, сургалт болсон талаар мэдээлэл аваагүй

27. Уул уурхайн асуудлаар шийдвэр гаргахад иргэдийн оролцооны талаарх сургалтын хэрэгцээ байна уу?

Маш их хэрэгцээтэй	Хэрэгцээтэй	Хэрэгцээгүй	Мэдэхгүй
4	3	2	1

27. Уул уурхайн асуудлаар шийдвэр гаргахад иргэдийн оролцооны талаарх сургалтын хэрэгцээ байна уу?

28. Энэ мэдлэг мэдээллээ ашиглаж чадаж байна уу, чадахгүй байгаа бол ямар хүндрэл байна?.....

29. Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах асуудлаар явуулах сургалт, уулзалтанд Та хэр идэвхтэй оролцох вэ?

1. Маш идэвхтэй оролцоно
2. Ер нь оролцоно
3. Зав гарвал оролцоно
4. Завгүй учраас оролцож амжихгүй
5. Одоогоор хэлж мэдэхгүй байна

30. Уул уурхай дахь иргэдийн оролцоог хангах зорилгын хүрээнд Танд ямар мэдээлэл хэрэгтэй байна, юу хийгээсэй гэж Та хүсч байна?

.....

31. Уул уурхайн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгахад ямар хэлбэрээр мэдээлэл хүргэвэл Танд мэдээлэл хүрэх вэ?

1. Сумын ЗДТГ, багийн байрны самбарт мэдээлэл гаргах
2. Цахим хуудсаар мэдээлдэг, шинэчилдэг



3. Уул уурхай, орон нутгийн захиргаа, иргэд малчдын уулзалтын протоколыг самбар болон уул уурхайн цахим хуудсанд байрлуулах
4. Уул уурхай, сум, баг, ИТХ тогтмол хугацаанд мэдээлэл, сонсгол, илтгэл тавьдаг байх
5. Уул уурхайн үйл ажиллагааны талаар нээлттэй өдөрлөг 3 талаас зохион байгуулдаг байх
6. Уул уурхайтай холбоотой иргэдийн санал, өргөдөл гомдол түүний шийдвэрлэлтийг уул уурхайн ААН болон сум, баг ил тод мэдээлдэг байх \орон нутгийн ТВ, самбар гэх мэт
7. Иргэдэд хурлын товыг хүргүүлдэг байх, хурлыг нээлттэй мэдээлдэг байх
8. Иргэд, малчдын гэр, ажлын байранд хурал, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах
9. Бусад \бичнэ үү\.....

32. Уул уурхайн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад иргэд, ИНБ, ТББ-ын оролцоог хангах хүрээнд Таньд ямар санал байна?

.....  
 .....

33. Та уул уурхайн ямар ямар үйл ажиллагаанд оролцож байсан бэ?

1. Уул уурхай эхлүүлэхээр нутгийн иргэд, малчдаас санал авах зорилготой уулзалт хэлэлцүүлэгт оролцсон
2. Уул уурхай эхлүүлэх үеийн болон уул уурхайн үйл ажиллагааны эерэг, сөрөг нөлөөлөл, нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, газар нутгийг танилцуулсан хурал уулзалт хэлэлцүүлэгт оролцсон
3. Уул уурхайн үйл ажиллагааны үеэр нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны хүрээнд хийсэн ажлыг тайлагнасан хуралд суусан
4. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, иргэдийн оролцоог хангах журмыг сурталчилсан сургалтад хамрагдсан
5. Уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нутгийн иргэдийн оролцоотой тогтоох хэлэлцүүлэг, ярилцлагад оролцож саналаа илэрхийлсэн
6. Уул уурхайн ААН йн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг нутгийн иргэдэд танилцуулж, хэлэлцүүлэх хурал уулзалтад оролцсон
7. Нөлөөлөлд өртсөн иргэд, малчдад нөхөн төлбөр олгох, нүүлгэн шилжүүлэлтийн асуудлаарх зөвлөлдөх хурал уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон
8. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтийг олон нийтэд танилцуулах уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон
9. Уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчинд гарсан нөлөөллийг хуулийн дагуу холбогдох байгууллагад мэдээлсэн
10. Дээр дурьдсан нэг ч үйл ажиллагаанд оролцож байгаагүй
11. Хурал уулзалтын талаарх мэдээлэл авч байгаагүй тул мэдэхгүй байна.

## 34. Та уул уурхайтай холбоотой дараах асуудлаар уул уурхайн ААН болон эрх бүхий албан тушаалтанд хандаж байсан уу?

	Тогтмол	Заримдаа	Хааяа нэг	Огт үгүй	Мэдэхгүй
Уул уурхайн хүн, мал, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн тухай ААН, сум, багийнн засаг даргад мэдээлдэг	1	2	3	4	99
Өвөлжөө хаваржаа, нутагладаг бэлчээр, ус уурхайн нөлөөлөлд өртсөн асуудлаар ИНБ, ТББ-уудад эрхээ хамгаалуулахаар хандсан	1	2	3	4	99
Өвөлжөө хаваржаа, нутагладаг бэлчээр, ус уурхайн нөлөөлөлд өртсөн асуудлаар шүүхэд эрхээ хамгаалуулахаар хандсан	1	2	3	4	99
Нөхөн төлбөр, нүүлгэн шилжүүлэлтийн асуудлаар уул уурхайн ААН, орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдэд өргөдөл гомдол гаргасан	1	2	3	4	99
Нөхөн төлбөр, нүүлгэн шилжүүлэлтийн асуудлаар уул уурхайн ААН, орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдэд өргөдөл гомдолд хариу өгч шийдвэрлэсэн	1	2	3	4	99
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг танилцуулах, тайлагнах хурал хэлэлцүүлэгт оролцдог	1	2	3	4	99
БОННУ-нд нөлөөллийг тогтоох, үнэлэхэд оролцож санал гаргасан	1	2	3	4	99
Тусгай зөвшөөрөл, ТЭЗҮ, БОННУ-тэй холбоотой зөрчил маргаантай асуудлаар ААН, нутгийн удирдлага, ТББ-д хандаж хамтарч ажилладаг	1	2	3	4	99

ТАНЬД БАЯРЛАЛАА

## 2. АСУУЛГЫН ХУУДАС (ОРОН НУТГИЙН МЭРГЭЖИЛТЭН)

Дэлхийн байгаль хамгаалах сан, Ногоон хөгжлийн хөтөч ТББ-ийн зөвлөх баг хамтран “Уул уурхайн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар Монгол орны ард иргэдийн болон мал сүргийн эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх ба байгаль орчныг хамгаалах нь” төслийн хүрээнд Батширээт, Биндэр сумын иргэд, малчдын уул уурхайн шийдвэр гаргалтад оролцох оролцоог тодорхойлох мэдлэг, хандлага, дадал (КАР survey) судалгааг явуулж байна. Таны хариулт уул уурхайд иргэдийн оролцоог хангах нөлөөллийн хөтөлбөрийг боловсруулахад хувь нэмрээ оруулна. Зөв, буруу хариулт байхгүй, Та өөрийн санаа бодолтой тохирох хариултыг сонгох, саналаа хуваалцана уу.

Ac01	Нас.....	Код	Чиглэл
Ac01	Албан тушаал, ажилласан жил .....	Код	Чиглэл
Ac03	Оршин суугаа орон нутаг	Код	Чиглэл
	Бөхмөрөн	1	
	Багийн нэр	2	

### НАРИЙВЧИЛСАН АСУУЛТ

#### ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Таны эрхэлдэг ажил, албан тушаал уул уурхай, байгаль орчин, иргэдийн оролцоотой холбогддог уу?

	Код
Тийм	01
Үгүй	02

1а. Хэрэв тийм бол хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд ямар асуудлыг хариуцаж ажилладаг вэ?

.....

Та уул уурхайн үйл ажиллагааг хэрхэн хүлээж авч байна?

	Код
Хариуцлагатай уул уурхайг дэмждэг	01
Ер нь уул уурхайг дэмждэггүй	02
Уул уурхайн үйл ажиллагааг бүрэн эсэргүүцдэг	03
Хэлж мэдэхгүй	99

Танай нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн талаар та хэр мэдэх вэ?

	Код
Сайн мэднэ	01
Ерөнхийдөө мэднэ	02
Ерөнхийдөө мэдээгүй	03
Огт мэдээгүй	04
Мэдэхгүй	99

Танай орон нутаг дахь уул уурхайн ААН удын үйл ажиллагааны талаарх мэдээллийг Та ямар эх сурвалжаар мэдээлэл авч байна? \Хамгийн чухал гэж үзсэн 3 хүртэл хариулт сонгоно\

	Код
Уул уурхайн ААН	01
Сум орон нутгийнхолбогдох албан тушаалтнаас \БОУБ г.м\	02
Иргэдийн санал гомдол	03
Телевиз	04
Сонин	05
Социаль медиа	06
Тараах материал	07
Нөхөрлөлийн ахлагч\гишүүд	08
Малчид	09
Иргэний хөдөлгөөн, ТББ	10
Мэдэхгүй	99

Та уул уурхайн үйл ажиллагаа, түүний шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах, талуудын оролцоо, санал санаачлага, хамтын ажиллагааг хэрэгжүүлсэн туршлага байна уу?

	Код
Хангалттай туршлагатай	01
Ерөнхийдөө ийм төрлийн үйл ажиллагаанд оролцож байсан	02
Туршлага байхгүй	03
Мэдэхгүй	99

Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах хүрээнд Танд ямар санаа оноо байна?

.....

Орон нутагт иргэд малчид уул уурхай, байгаль орчинтой холбоотой асуудлаар хүссэн мэдээллээ авах боломж байна уу?

	Код
Бүрэн боломжтой	01
Ерөнхийдөө боломжтой	02
Дунд зэрэг	03
Хангалтгүй	04
Мэдэхгүй	99

Сум, багийн иргэд, малчид байгаль хамгаалах сайн дурын үйл ажиллагаа, хамтын оролцоотой байгаль хамгаалах, нутгийн иргэдийг төлөөлөх үүсгэл санаачлага хэр зэрэг ажиглагддаг вэ?

	Код
Ойн нөхөрлөлүүд ойн санг хамгаалдаг	01
Сайн дурын идэвхтэн байгаль хамгаалагч хулгайн ан, хууль бус мод бэлтгэл, уул уурхайн хууль бус үйл ажиллагаатай холбоотой зөрчлийн талаар мэдээлдэг	02

Малчдын бүлэг, нөхөрлөл	03
Хангалтгүй	04
Мэдэхгүй	99

Та уул уурхайн асуудлаар иргэд, малчидтай ямар хэлбэрээр харилцах нь тохиромжтой гэж боддог вэ ?

	Код
ИТХ-ын хурал	01
Сумын ЗД-ын зөвлөлийн хурал	02
Багийн хурал	03
Биечлэн хөдөөгүүр явж гэрээр нь зочилдог	04
Бусад:.....	
Мэдэхгүй	99

Иргэд, малчдаас уул уурхай, байгаль орчинтой холбоотой ямар асуудал дэвшүүлдэг вэ?

	Код
Уул уурхайн хууль бус үйл ажиллагаа	01
Байгаль орчны тулгамдсан асуудал	02
Уурхайг ажиллуулахгүй гэсэн эсэргүүцэл	03
Нөхөн олговор, газар чөлөөлөлт	04
Өмчлөх, эзэмших эрхэд халдсан	05
Уул уурхайтай холбоотой асуудлаар мэдээлэл хүсдэг	06
Уул уурхайтай холбоотой хууль дүрэм журмын тухай мэдээлэл хүсдэг	07
ИНБ, ТББ, өмгөөлөгчид хандах асуудлаар	08
Бусад.....бичнэ үү?	
Мэдэхгүй	99

Орон нутагт байгалийн баялаг олборлох үйл ажиллагаанд хэн голлон хяналт тавих ёстой вэ?

	Код
Орон нутгийн захиргаа	01
Иргэд	02
ИНБ, ТББ	03
Засгийн газар	04
Засгийн газартай гэрээ байгуулсан хувийн ААН уд	05
Бусад	
Мэдэхгүй	99

Уул уурхайн салбарын талаар дараах талууд хэр зэрэг итгэл үнэмшилтэй зүйл ярьдаг вэ?

Оролцогч талууд	Маш үнэмшилтэй	Ерөнхийдөө үнэмшилтэй	Ерөнхийдөө үнэмшилгүй	Огт үнэмшилгүй	Мэдэхгүй
Засгийн газар	1	2	3	4	99
Аймгийн захиргаа	1	2	3	4	99
Сум, орон нутгийн захиргаа	1	2	3	4	99
Асуудал хариуцсан мэргэжилтэн	1	2	3	4	99
Уул уурхайн ААН					
Багийн захиргаа	1	2	3	4	99
Хэвлэл мэдээлэл	1	2	3	4	99
Нутгийн нэр хүндтэй хүмүүс	1	2	3	4	99
Ойн болон малчдын бүлгийн гишүүд	1	2	3	4	99
Малчдын бүлэг	1	2	3	4	99
Загасчдын клуб	1	2	3	4	99
Эко клуб	1	2	3	4	99
Нөлөөллийн бүсийн иргэд	1	2	3	4	99
Судалгаа шинжил/гээний байгууллага	1	2	3	4	99
Эмэгтэйчүүдийн ТББ	1	2	3	4	99

Та Монголын уул уурхайн салбар дахь дотоодын ААН удын оролцоог дэмждэг үү эсвэл эсэргүүцдэг үү?

	Код
Маш их дэмждэг	01
Ерөнхийдөө дэмждэг	02
Ерөнхийдөө дэмждэггүй	03
Огт дэмждэггүй	04
Мэдэхгүй	99



Уул уурхайн салбар дахь иргэдийн оролцоо, орон нутгийн захиргааны байгууллагын оролцоог тодорхойлсон тусгай хууь батлахыг та дэмжих үү эсвэл эсэргүүцэх үү?

	Код
Их дэмжинэ	01
Ерөнхийдөө дэмжинэ	02
Ерөнхийдөө эсэргүүцнэ	03
Их эсэргүүцнэ	04
Мэдэхгүй/хариулаагүй	99

Уул уурхайг хөгжүүлэхэд уул уурхайн ААН юунд хамгийн их анхаарах ёстой гэж та боддог вэ?

	1-р сонголт	2-р сонголт
Монгол иргэдийг ажлын байраар хангах	01	01
Иргэдийн оролцоог хангах, иргэдийн дуу хоолойг сонсох, санал санаачлагад үндэслэн хамтын шийдвэр гаргах	02	02
Нийгмийн дэд бүтцэд хөрөнгө оруулах (сургууль, эмнэлэг гэх мэт)	03	03
3, 4 талт хамтын ажиллагааг бий болгох	04	04
Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх	05	05
Байгаль орчныг хамгаалах	06	06
Дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах	07	07
Ашиг орлого, нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлэх	08	08
Бусад	09	09
Мэдэхгүй	99	99

Уул уурхайн ААН удын талаарх таны бодол эерэг үү ? эсвэл сөрөг үү?

	Код
Маш эерэг	01
Ерөнхийдөө эерэг	02
Ерөнхийдөө сөрөг	03
Маш сөрөг	04
Мэдэхгүй	99

Танай нутагт олгогдсон бусад уул уурхайн А лицензтэй ААН йн талаарх таны бодол эерэг үү сөрөг үү?

	Код
Маш эерэг	01
Ерөнхийдөө эерэг	02
Ерөнхийдөө сөрөг	03
Маш сөрөг	04
Мэдэхгүй	99

Уул уурхайн ААН уд нутгийн иргэд, малчдын санаа бодол, хэрэгцээг сонсдоггүй гэдэгтэй та санал нийлэх үү?

	Код
Бүрэн санал нийлнэ	01
Ерөнхийдөө санал нийлнэ	02
Ерөнхийдөө санал нийлэхгүй	03
Огт санал нийлэхгүй	04
Мэдэхгүй	99

Уулуурхайн ААН уд орон нутгийн захиргаа, тэдгээрийн мэргэжилтнүүдтэй хамтарч ажилладаггүй гэдэгтэй санал нийлэх үү?

	Код
Бүрэн санал нийлнэ	01
Ерөнхийдөө санал нийлнэ	02
Ерөнхийдөө санал нийлэхгүй	03
Огт санал нийлэхгүй	04
Мэдэхгүй	99

Таны мэдээлэл авдаг гол сурвалж тань аль нь вэ? (Зөвхөн нэг хариултыг сонгоно)

	Код
Телевиз	01
Радио	02
Сонин	03
Интернет	04
Нийгмийн сүлжээ буюу Facebook, Twitter г.м	05
Бусад	06
Мэдэхгүй	99

Уул уурхайн ААН удаас өгч буй мэдээллийг хэр зэрэг үнэн бодит, ил тод байна гэж боддог вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно)

	Код
Тухайн мэдээлэл бүгд үнэн гэж боддог	01
Тухайн мэдээллийн ихэнх нь үнэн гэж боддог	02
Тухайн мэдээллийн ихэнх нь худал гэж боддог	03
Тухайн мэдээлэл бүгд худал гэж боддог	04
Мэдэхгүй	99

Уул уурхайн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах төсөл хэрэгжих гэж байна. Та энэхүү төслөөс юу хүсэн хүлээж байна вэ?

.....

Энэ төсөл орон нутагт иргэдийн оролцоог хангах хүрээнд Таньтай хэрхэн хамтарч ажиллаасай гэсэн хүлээлт байна вэ?

.....

### 3. АСУУЛГЫН ХУУДАС (УУЛ УУРХАЙН ААН)

Дэлхийн байгаль хамгаалах сан, Ногоон хөтөч ТББ-ийн зөвлөх баг хамтран “Уул уурхайн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар Монгол орны ард иргэдийн болон мал сүргийн эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх ба байгаль орчныг хамгаалах нь” төслийн хүрээнд уул уурхайн шийдвэр гаргалтад талуудын оролцоог тодорхойлох мэдлэг, хандлага, дадал (KAP survey) судалгааг явуулж байна. Таны хариулт уул уурхайн үйл ажиллагаанд талуудын тэнцвэртэй оролцоог хангах нөлөөллийн хөтөлбөрийг боловсруулахад хувь нэмрээ оруулна. Зөв, буруу хариулт байхгүй, Та өөрийн санаа бодолтой тохирох хариултыг сонгох, саналаа хуваалцана уу.

#### Хяналтын хэсэг

	Нэр	Код	Судалгаа авсан			
Үйл ажиллагаа явуулж буй сумын нэр			Он			
Үйл ажиллагаа явуулж буй Багийн нэр			Сар			
Судалгаанд оролцогчийн утас			Өдөр			

#### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Таны нас [.....]
2. Хүйс 1. Эмэгтэй 2. Эрэгтэй
3. Боловсрол 1. Дээд  
2. Тусгай дунд  
3. Бүрэн дунд  
4. Бүрэн бус дунд
5. Уул уурхайн ААН йн нэр.....
6. Уул уурхайн ААН д эрхэлдэг ажил.....
7. Танай ААН хэдэн жил энэ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна? .....
8. Танай ААН ямар лицензийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна?
  1. Хайгуулын лиценз
  2. Ашиглалтын лиценз
9. Танай уул уурхайн ААН йн хайгууль, ашиглалтын үйл ажиллагаанаас хэдэн км-ын зайд иргэд, малчид нутаглаж байна? .....
10. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас хүн, малын эрүүл мэнд байгаль орчинд ямар нэгэн эрсдэл, нөлөөлөл гарч байна уу?
  1. Тийм, эрсдэл гарч байгаа
  2. Тийм, гэхдээ бага
  3. Эрсдэл байхгүй
  4. Хэлж мэдэхгүй

11. Танай ААН д олон нийттэй харилцах алба, хэлтэс, мэргэжилтэн байдаг уу?

1. Олон нийттэй харилцах алба, хэлтэстэй
2. Олон нийттэй харилцах ажилтантай
3. Аль аль нь байхгүй

10. Танай ААН орон нутгийн удирдлага, иргэд, малчидтай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг уу?

1. Тийм
2. Үгүй

11. Хэрэв тийм бол хамтын ажиллагааны гэрээний биелэлт, үр дүнгийн талаар мэдээлэл өгнө үү?

	Хариулт
Хэдэн онд гэрээ байгуулагдсан	
Гэрээ байгуулах саналыг аль тал гаргасан бэ?	
Гэрээнд оролцогч ямар ямар талууд байна?	
Гэрээгээр зохицуулсан голлох үйл ажиллагаа	
Гэрээг тогтмол дүгнэж, хуралдаж байна уу	
Гэрээгээр хүлээсэн үүргээ ААН хэр зэрэг биелүүлж байна?	
Гэрээнд дурьдагдсан асуудлаас ямар асуудал биелэхгүй байна	

12. Хэрэв хамтран ажиллах гэрээгүй бол яагаад?

.....

## 2. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАЛУУДЫН ОРОЛЦОО

13. Орон нутагт хамгийн ойр хамтарч ажилладаг хүмүүс хэн бэ?

1. Сумын ЗД
2. Багийн ЗД
3. Байгаль орчны улсын байцаагч
4. Идэвхтэн байгаль хамгаалагч
5. Нөлөөллийн бүсийн малчид, иргэд
6. Нөхөрлөлийн ахлагч, гишүүд
7. Иргэд, малчид
7. Аймгийн Мэргэжлийн хяналтын байцаагч
8. Бусад.....\бичнэ үү?\

14. Сум орон нутагт уурхайн үйл ажиллагаагаа танилцуулах уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж байсан уу?

1. Жилдээ 1-2 удаа хурал хийдэг
2. Улирал, сар тутамд хурал хийдэг
3. Багийн хурал дээр ирж танилцуулга хийдэг
4. Малчин айл өрхүүдээр орж үйл ажиллагаагаа танилцуулдаг
5. Хурал уулзалт зохион байгуулж байгаагүй
6. Бусад .....

15. Иргэд уул уурхайгаас ямар мэдээлэл хүсдэг вэ, та бүхэн тэрхүү мэдээлэлд ямар хариу мэдээллийг ямар хэлбэрээр өгч байна вэ?

Иргэдээс уурхайгаас хүсдэг, мэдэхийг хүсдэг мэдээлэл	Иргэдээс уурхайд гаргадаг гомдол, хүсэлт	Уул уурхайн ААН ас үүнд ямар хариу өгдөг

16. Орон нутагт уурхайн үйл ажиллагаа явуулж буй танай ААН дараах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулж хамтарсан туршлага байна уу?

	Тийм, ганц нэг удаа	Үе цөөн тохиолдолд	Үгүй	Шаардлагагүй гэж боддог
Уул уурхайн үйл ажиллагаа эхлүүлэх тухай танилцуулга	1	2	3	4
Уул уурхайн үйл ажиллагааны хүн ам, бэлчээр, байгалийн нөөцөд учруулах нөлөөллийн тухай	1	2	3	4
БОМТ болон түүний тайлагнал	1	2	3	4
БОНБНҮ	1	2	3	4
Уул уурхайн үйл ажиллагааны	1	2	3	4
Сөрөг нөлөөллийг буурлуулах, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа	1	2	3	4
Нүүлгэн шилжүүлэлт	1	2	3	4
Нөхөн олговор	1	2	3	4
Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байдал	1	2	3	4
Иргэд малчидтай хэрхэн хамтран ажиллах тухай үйл ажиллагааны төлөвлөгөөний танилцуулга	1	2	3	4

17. Уул уурхайн үйл ажиллагаанд талуудын тэнцвэртэй оролцоог хангах, ялангуяа иргэдийн оролцоог хангах тухай хууль тогтоомж, тушаал шийдвэрийн талаарх хэр мэдээлэлтэй вэ?

1. Сайн мэдээлэлтэй
2. Ерөнхий мэдээлэлтэй
3. Бага мэдээлэлтэй
4. Огт мэдээлэлгүй

18. Цаашид уурхайн үйл ажиллагаанд талуудын эрх тэгш оролцоог хангах талаар Та юу гэж бодож байна?

.....

19. Уул уурхайн үйл ажиллагаанд талуудын тэгш оролцоог бий болгох хүрээнд уул уурхайн ААН-ын зүгээс ямар санаачлага гарган ажиллах вэ?

20. Уул уурхайн үйл ажиллагаанд нутгийн иргэд, малчдын оролцоог хангах, тэдэнтэй хамтарч ажиллах ямар арга зам байна гэж Та харж байна?

.....

21. Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулахад ямар хүндрэл бэрхшээлтэй байдаг вэ ?

.....

.....



# ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-ГИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР

## 1992 он

Монгол Улсад 1992 онд байгуулагдсан.

## 10.6 сая га

Нийт 10.6 сая га газрыг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулсан нь нийт хамгаалалттай газар нутгийн 39 хувийг эзэлж байна.

## 2 газар нутаг

Алтай-Соёны бүс нутаг болон Амар мөрний сав газарт ажилладаг.

## 5 сав газар

Усны нөөцийн нэгдсэн менежментийг Хар нуур-Ховд, Онон, Хяргас нуур-Завхан, Хэрлэн болон Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газруудад санаачлан хэрэгжүүлж байна.

## 5

Цэнгэг ус, ойн экосистем, цоохор ирвэс, Монгол бөхөн зэрэг нэн ховор амьтан, тал хээрийн нуруутны нүүдэл гэсэн экологийн процессыг төлөөлөл болгон сонгон авч байгаль хамгааллын үйл ажиллагаа явуулж байна.

## +140

Нийт 140 гаруй байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл байгуулан, дэмжин ирсэн.

## +600

Бид байгаль хамгаалах 24 клубын 600 гаруй сурагчидтай хамтарч ажилладаг.

## 2013 он

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай байгуулсан гэрээний дагуу 2013 оноос эхлэн Хар ямаатын байгалийн нөөц газрын менежментийг хариуцан ажиллаж байна.

Хавтасны зургийг: Б.Гантулга



Бидний эрхэм зорилго: Монгол орон зэрлэг ан амьтан, ургамлын өлгий нутаг байж, хүн ард нь байгальтайгаа шүтэлцэн үеийн үед сэтгэл хангалуун амьдрах ирээдүйг бүтээхэд оршино.

Холбоо барих хаяг:

Утас: +(976)-11-311658

Факс: +(976)-11-310237

И-мэйл: info@wwf.mn